



СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН
ЯАМ



TOURISM WEEK 2026

MONGOLIA

· ALWAYS · MOVING ·



FOUR SEASONS TRAVEL OF MONGOLIA



SPRING / 2026

four seasons

PANORAMIC CITY VIEW



Naadam Bar & Restaurant, Shangri-La Ulaanbaatar
19 Olympic Street, Sukhbaatar District-1, Ulaanbaatar 14241 Mongolia
Reservations: (+976) 7702 9999

GREETINGS

MONGOLIA
· ALWAYS · MOVING



СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН
ЯАМ

САЙДЫН МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм хүндэт хатагтай, ноёд та бүхний амар
амгаланг айлтгая,

Монгол улс урт хугацааны хөгжлийн бодлогодоо аялал жуулчлалыг эдийн засгийн тэргүүлэх салбар хэмээн тодорхойлсон. Монгол Улсын Засгийн газраас “Монголд зочлох жил” болгон зарлаж, аялал жуулчлалын салбарт шинэ сэргэлтийг эхлүүлж, бодлого, хууль эрх зүй, бүтээгдэхүүн үйлчилгээ, дэд бүтэц хөгжүүлэлт, олон улсын сурталчилгаа зэрэг бүх түвшинд төр, хувийн хэвшил, мэргэжлийн байгууллагууд хамтдаа хүчин чармайлт гарган ажиллаж байна.

Салбарынхны хамтын зүтгэл үр дүнгээ өгч, Монгол Улсад зочлон ирэх жуулчдын тоо жилээс жилд тогтвортой нэмэгдэж, НҮБ-ын харьяа Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын (UNWTO) тайлангаар дэлхийн хамгийн өндөр өсөлттэй 20 орны тоонд багтаж, Монгол Улсын эдийн засагт бодитой үр дүнгээ үзүүлжээд байна. Энэ хурдацтай хөгжил, өсөлтөд чухал нөлөөллийг үзүүлсэн аялал жуулчлалын салбарын хамт олон та бүхэнд гүн талархал илэрхийлье.

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам нь энэхүү өсөлтийг цаашид үргэлжлүүлэн хадгалахын зэрэгцээ нүүдэлчин өв соёл, зан заншил, түүх өв, унаган байгаль зэрэг үндэсний үнэт баялгаа түшиглэсэн төрөлжсөн, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэхийг зорьж байна. Үүний хүрээнд аялал жуулчлалын хөгжлийн орон зай, тусгай болон кластер бүсүүдийг тодорхойлж нэгдсэн зохион байгуулалт, байгаль, соёлын өвд ээлтэй хөгжлийн загварыг хөгжүүлэхэд анхааран ажиллаж байна.

Мөн улирлын хамаарлыг бууруулах буюу дөрвөн улирлын жуулчны урсгалыг дэмжих, үйлчилгээний байгууллагын тоо, багтаамж, үйлчилгээний чанарыг сайжруулах, дэд бүтцийг хөгжүүлэх зорилгоор хөнгөлөлттэй зээл гаргах, хүний нөөцийг нэмэгдүүлэх, чадавхжуулах зэрэг ажлуудыг үе шаттайгаар хэрэгжүүлэхээр зорин ажиллаж байна.

Аялал жуулчлалын салбарын хамт олон та бүхний үйлс бүхэн тань өөдөө байхыг чин сэтгэлээсээ хүсэн ерөөе.

Монгол эх орон минь өнө мөнх,
Өв соёл минь ариун тунгалаг,
Түмэн олон минь амар амгалан байх болтугай!

Монгол Улсын Их Хурлын Гишүүн,
Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд:
Чинбатын УНДРАМ

МОНГОЛ НҮҮДЛИЙН ЗАН ҮЙЛ ӨВ ЮНЕСКО-Д БҮРТГЭГДЛЭЭ

UNESCO-ийн Соёлын биет бус өвийг хамгаалах тухай конвенцын Засгийн газар хоорондын хорооны 19 дүгээр чуулган 2024 оны 12 дугаар сарын 02–07-ны өдрүүдэд Asunción хотноо зохион байгуулагдлаа.

Чуулганы 12 дугаар сарын 5-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсаас нэр дэвшүүлсэн “Монгол нүүдлийн зан үйл” өвийг хэлэлцэн, хорооны гишүүдийн 100 хувийн саналаар UNESCO-ийн Хүн төрөлхтний соёлын биет бус өвийн Төлөөллийн жагсаалтад бүртгэлээ. Ийнхүү Монгол Улс соёлын биет бус өвийн жагсаалтад бүртгүүлсэн 16 дахь өвөө батламжлуулсан түүхэн үйл явдал боллоо.

НҮҮДЛИЙН ЗАН ҮЙЛИЙН ҮНЭ ЦЭНЭ

“Монгол нүүдлийн зан үйл” нь нүүдэлчдийн олон мянганы турш байгаль, цаг уур, мал аж ахуй, ахуй амьдралын хэв маягтайгаа уялдуулан бүтээж, үеэс үед өвлүүлэн ирсэн уламжлалт мэдлэгийн цогц тогтолцоо юм.

Үүнд:

Нүүх нутаг, бэлчээр сонгох
Нүүх өдөр, судар товлох
Ачаа тээш бэлтгэх, нүүдэл ачааллах
Бууц, бууриа цэвэрлэх
Шинэ буусан газраа аргадах
Бэлчээрийн даац, нөөцийг мал сүргийн бүтэц, тоо толгой, зэрлэг амьтан, ургамлын тархацтай уялдуулах

Байгаль дэлхийгээ хамгаалан зохистой ашиглах зэрэг уламжлалт мэдлэг, зан үйлийн иж бүрэн тогтолцоо багтдаг.



ӨВ УЛАМЖЛАЛ АМЬД ХЭВЭЭР

Хүн, байгаль, мал гурвын харилцан шүтэлцээнээс үүдэн бий болсон энэхүү уламжлал өнөөдөр ч амьдрал дээр үргэлжилсээр байна.

Алтайн өндөр ууланд тэмээгээр
Хангайн бүсэд сарлагаар
Говьд тэмээгээр
Тал хээрт тэмээ болон хөсөг тэргээр
Тайгын бүсэд цаа бугаар нүүдэллэх зан үйл
үргэлжилж, уламжлалт мэдлэг тасралтгүй өвлөгдөн хадгалагдсаар байгаа нь Монгол соёлын онцлог, амьд дархлаа билээ.

Монгол нүүдлийн зан үйл – байгальтайгаа зохицон орших ухааны дэлхийн жишиг өв.

Photo by: Battulga P., Mongolia, 2019



Photo by: Delgermaa



51-265626



info@moc.gov.mn



moc.gov.mn



ЕРӨНХИЙЛӨГЧИЙН МЭНДЧИЛГЭЭ

Монгол Улсын аялал жуулчлалын тогтвортой хөгжлийн төлөө мөр зэрэгцэн хамтран ажиллаж буй аялал жуулчлалын салбарынхан, Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны гишүүдийнхээ амгаланг айлтгая. “Аялал Жуулчлалын Мэргэжлийн Холбоо” (MONGOLIA TOURISM ORGANIZATION) нь аялал салбарын хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэгч, салбарын нийт оролцогчдын бүртгэл мэдээлэл, улс орны аялал жуулчлалын нийтлэг маркетингийн чиг үүргийг гүйцэтгэгч нийтийн эрх зүйн хуулийн этгээд юм. Манай холбоо салбарын бодлогын хэрэгжилт, мэргэжлийн стандарт, хариуцлагыг бэхжүүлэх, төр-хувийн хэвшлийн уялдаа холбоог сайжруулах гэх мэт олон чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

“Аялал Жуулчлалын Мэргэжлийн Холбоо” байгуулагдсанаас хойш аялал жуулчлалын тогтвортой хөгжил, зах зээлийг тэлэх, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх зэрэг томоохон зорилтуудыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулж ирлээ. Энэ хүрээнд олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнгүүдэд нэгдсэн зохион байгуулалтайгаар оролцох, “Go Mongolia” олон улсын сурталчилгааны цуврал арга хэмжээ, Tourism Week - Аялал жуулчлалын чуулган зохион байгуулах, Бүсчилсэн хөгжлийн бодлогод тулгуурлан салбарын хөгжлийг хамтран тодорхойлох, орон нутагт салбар холбоодыг байгуулж, нэгдсэн бодлого, удирдлагаар хангаж ажиллах зэрэг бодит үр дүнтэй олон хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн.

Мөн салбарын тур оператор, аяллын агент, зочид буудал, жуулчны бааз, дэн буудал, амралтын газар, сувилал, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын бизнес эрхлэгч, жуулчны хөтөч тайлбарлагч, жуулчин тээврийн үйлчилгээ эрхлэгч, гар урлал эрхлэгч, үндэсний сүлжээ дэлгүүрүүдээс бүрдсэн 700 гаруй аж ахуйн нэгжийг эгнээндээ нэгтгэж, цаашид гишүүн байгууллагуудын оролцоо, хамтын ажиллагаанд тулгуурлан салбарын хөгжлийн бодлого тодорхойлоход мэргэжлийн оролцоог хангах, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, олон улсын түншлэлийг өргөжүүлэх чиглэлд анхаарч ажиллах болно. Бидэнд итгэж, бидэнтэй хамтран ажиллаж ажиллаж ирсэн Монгол Улсын Засгийн газар, Соёл, Спорт, Аялал Жуулчлал, Залуучуудын Яам, болон Зам Тээврийн, Гадаад Хэргийн Яам, Гэр бүл, Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам, 21 аймгийн, орон нутгийн удирдлагууд, МҮХАТанхим, Мэргэжлийн холбоод, Олон улсын хамтын ажиллагааны байгууллагууд болон салбарын нийт бизнес эрхлэгчдэд гүн талархал илэрхийлье.

Аялал Жуулчлалын Мэргэжлийн Холбоо
Mongolia Tourism Organization

Төмөрдашийн БАТТУЛГА



Mr. Katsuhisa Ishizaki

Director for International Affairs Department
Regional Support Office for Asia and the Pacific, UN Tourism

НҮБ-ын Аялал жуулчлалын байгууллага (UN Tourism) Ази Номхон далайн бүсийн төлөөлөгчийн газар нь 1995 онд Япон улсад (одоогийн байршил: Нара хот) байгуулагдсан бөгөөд бүс нутгийн аялал жуулчлалыг дэмжих, тогтвортой хөгжлийг хангах, гишүүн орнуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилготой юм. Манай байгууллага тогтвортой аялал жуулчлалын бодлогыг хэрэгжүүлэх, судалгаа шинжилгээ хийх, семинар болон сургалт зохион байгуулах, мэдээлэл түгээх зэрэг үйл ажиллагааг явуулж байна.

Манай байгууллага өмнө нь Вьетнамын Аялал жуулчлалын ерөнхий газартай хамтран тус улсын орон нутгийн хотуудад тогтвортой аялал жуулчлалыг дэмжих зорилгоор семинар, цахим сургалт зохион байгуулсан бөгөөд хамтын ажиллагааны дүнг нэгтгэн Хошимин хотод симпозиум хийсэн. Мөн UN Tourism-аас санаачилсан “Best Tourism Villages” хөтөлбөрийн хүрээнд хүн амын тоо харьцангуй бага, хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загасчлал зэрэг уламжлалт үйлдвэрлэлд тулгуурласан аялал жуулчлалын бүс нутгийг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Цаашид Монгол Улсад Япон улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (JICA), Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам болон Mongolia Tourism Organization зэрэг байгууллагуудтай хамтран, ялангуяа орон нутгийн бүс нутагт тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэхэд чиглэсэн бодитой, газар дээр нь хэрэгжүүлэх үйл ажиллагааг өрнүүлэхээр төлөвлөж байна.

Takahiko Makino (Mr.)

JICA Sustainable Tourism Development Advisor to Mongolia's Ministry of Tourism

JICA нь 2019 оноос Монгол Улсад тогтвортой аялал жуулчлалын судалгаа хийж, түүний үр дүнд үндэслэн 2022–2024 онд тогтвортой аялал жуулчлалыг хэрэгжүүлэх бодлогын зөвлөмж өгөх, хэрэгжүүлэх чадавхыг нэмэгдүүлэх, хамтрагч байгууллагын маркетингийн стратеги хэрэгжүүлэх чадавхыг бэхжүүлэх, аялал жуулчлалын байгууллага, бизнес эрхлэгчдийн бүтээгдэхүүн хөгжүүлэлт болон сурталчилгааны чадавхыг сайжруулах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн.

Одоогийн байдлаар JICA нь “Тогтвортой аялал жуулчлалын хөгжил”-ийн чиглэлээр мэргэжилтэн илгээж, би Монгол Улсад Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамыг гол хамтрагчаар сонгон, өнгөрсөн оны 12-р сараас эхлэн ажиллаж байна.

Төслийн үйл ажиллагааны хүрээнд тогтвортой аялал жуулчлалын олон улсын гэрчилгээний нэг болох Green Destinations, Best Tourism Village by UN Tourism зэрэгт өргөдөл гаргах дэмжлэг үзүүлэн ажиллана. Үүний зэрэгцээ, Монгол Улсын хэмжээнд хэрэгжиж буй “**GO MONGOLIA**” урианы дор аялал жуулчлалын бүс нутгийн түвшинд брэндинг хөгжүүлэх, тухайн бүс нутгийн онцлог, давуу талыг тодорхойлох ажлыг хийж байна. Мөн аялал жуулчлалын хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах сургалт, үйл ажиллагааг Монголын аялал жуулчлалын мэргэжлийн холбоо (НЭЗХЭ), орон нутгийн аялал жуулчлалын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж байгаа юм.





МОНГОЛ УЛС АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН СЭРГЭЛТЭЭРЭЭ ДЭЛХИЙН ШИЛДЭГ 20 ОРНЫ ТООНД БАГТЛАА

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Дэлхийн Аялал Жуулчлалын Байгууллагаас (UN Tourism) гаргасан World Tourism Barometer, 2025 оны 11 дүгээр сар тайланд Монгол Улс аялал жуулчлалын салбарын сэргэлт, өсөлтийн үзүүлэлтээрээ дэлхийн шилдэг гүйцэтгэлтэй орнуудын нэг болохыг албан ёсоор баталгаажууллаа. Тус тайланд дурдсанаар, 2025 оны эхний 9 сард Монгол Улсад ирсэн олон улсын жуулчдын тоо 2019 онтой харьцуулахад 44 хувиар өссөн нь цар тахлын өмнөх түвшинг давж сэргэсэн, амжилттай орны нэг болсныг харуулж байна. Энэ үзүүлэлтээр Монгол Улс дэлхийн хэмжээнд жуулчдын урсгалаа хамгийн амжилттай сэргээсэн 20 орны жагсаалтад багтжээ.

АЗИ, НОМХОН ДАЛАЙН БҮСИЙН ДУНДАЖИЙГ ДАВСАН ӨСӨЛТ

UN Tourism-ийн мэдээллээр Ази, Номхон далайн бүс нутаг нийт дүнгээрээ цар тахлын өмнөх 2019 оны түвшнээс хараахан бүрэн сэргээгүй байгаа ч Монгол Улс уг бүсэд дундаж үзүүлэлтээс давсан өсөлт үзүүлж, сэргэлтийг амжилттай хурдасгасан орнуудын нэгээр нэрлэгдсэн байна.

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ОРЛОГО БОДИТООР НЭМЭГДЭВ

Зөвхөн жуулчдын тоо өсөөд зогсохгүй эдийн засгийн өгөөж ч мэдэгдэхүйц нэмэгджээ. Тайланд дурдсанаар:




Top 20 best-performing destinations in earnings Jan-Sep 2025*

International tourism receipts
% change vs. 2019¹

Source: UN Tourism
(Data as of November 2025)

* Destinations which have reported data for
at least January to August 2025.

¹ Change in local currencies if so reported
by the destination, otherwise in US dollars.



19

- 2025 оны эхний 9 дүгээр сард Монгол Улсын аялал жуулчлалын орлого өмнөх оноос 15 хувиар өссөн,
- Харин 2019 онтой харьцуулахад 39 хувиар нэмэгдсэн нь Монгол Улс аялал жуулчлалын салбараас илүү өндөр үнэ цэн бүхий орлого бүрдүүлж эхэлснийг илтгэж байна. Эдгээр үзүүлэлт нь жуулчдын дундаж зарцуулалт, аяллын хугацаа, үйлчилгээний чанар сайжирч, зах зээлийн бүтэц илүү тогтвортой болж байгааг харуулж байна.

UN TOURISM-ИЙН АЛБАН ЁСНЫ ТАЙЛАНД СУУРИЛБАЛ МОНГОЛ УЛС

- Цар тахлын дараах аялал жуулчлалын сэргэлтийг амжилттай хэрэгжүүлсэн,
 - Жуулчдын тоо, орлого, зах зээлийн бүтцийн хувьд олон улсын түвшинд өрсөлдөхүйц гүйцэтгэл үзүүлсэн,
 - Нүүдэлчин соёл, байгальд суурилсан тогтвортой аялал жуулчлалын бодлого нь бодит үр дүн өгч эхэлснийг бататгалаа.
- Эдгээр амжилт нь Монгол Улсын аялал жуулчлалын салбар тогтвортой өсөлтийн шинэ шатанд орсныг харуулж, цаашдын хөрөнгө оруулалт, олон улсын хамтын ажиллагаанд чухал эерэг дохио болж байна.

Key findings

World Tourism Barometer
November 2025

International arrivals up 5% in first nine months of 2025

- Over 1.1 billion international tourists (overnight visitors) travelled internationally between January and September 2025, about 50 million more than in 2024, a 5% year-on-year increase.
- Most destinations enjoyed strong travel demand despite high inflation in tourism services and mixed consumer confidence due to geopolitical and trade tensions. The third quarter saw a 4% increase in arrivals, reflecting a robust summer season in the Northern Hemisphere.
- Europe, the world's largest destination region, recorded 625 million international tourists during the first nine months of 2025, a 4% increase from the same period in 2024 and 6% more than in 2019.
- Africa recorded 10% growth in international arrivals this period, the strongest results by region. The Americas saw a 2% increase, with 3% growth in Q1 and Q2 but a 1% drop in Q3 due to small declines in the United States and Canada.
- Arrivals in the Middle East increased 2%, exceeding pre-pandemic levels by 33%, the strongest results relative to 2019.
- In Asia and the Pacific arrivals grew 8% this nine-month period, but remained 10% below 2019 levels, as the region continued to rebound.
- Results are in line with our global projection of 3% to 5% growth in arrivals for 2025.



3

More information: <https://en.unwto-ap.org/news/worldtourismbarometer>


International tourist arrivals by region

% change from 2019

World

2023: -10%
2024: +0%
Jan-Sep 2025: +3%

Source: UN Tourism
(Data as of November 2025)
Jan-Sep 2025 data are provisional



The designations and images in this map do not imply the expression of opinions whatsoever on the part of the Secretariat of the World Tourism Organization (UN Tourism) concerning the legal status of any country, territory, or of its authorities, or concerning the delimitation of its frontiers.



АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО (Нийтийн эрх зүйн хуулийн этгээд)

ТАНИЛЦУУЛГА

Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо нь Монгол Улсын аялал жуулчлалын салбарт хуульд суурилсан засаглалыг төлөвшүүлж, төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааг нэгтгэн, үндэсний брэндийг олон улсад таниулж буй салбарын төв байгууллага юм.

Тус холбоо нь Монгол Улсын Аялал жуулчлалын тухай хуулийн 26 дугаар зүйлд заасны дагуу байгуулагдсан, аялал жуулчлалын салбарын тур оператор, аяллын агент, зочид буудал, жуулчны бааз, жуулчин тээвэр, жуулчны хөтөч-тайлбарлагч, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалын үйлчилгээ эрхлэгчдийг нэгтгэсэн ашгийн төлөө бус, нийтийн эрх зүйн хуулийн этгээд юм.

Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо нь төрөөс хараат бус байдлаар үйл ажиллагаа явуулж, хуульд заасан чиг үүргийн хүрээнд төрийн зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлэн, салбарын бодлого, стандарт, хүний нөөц, олон улсын хамтын ажиллагаа, маркетинг, хөрөнгө оруулалтыг нэг цонхоор уялдуулан зохион байгуулагч үндэсний институт болон ажиллаж байна.

Өнөөдрийн байдлаар “Аялал Жуулчлалын Мэргэжлийн Холбоо” (MONGOLIA TOURISM ORGANIZATION) нь дотоод, гадаадын зах зээлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг салбар холбоод, орон нутгийн аялал жуулчлалын холбоод болон мэргэжлийн байгууллагуудыг нэгтгэсэн 400 гаруй гишүүнтэй үндэсний хэмжээний бүтэц болон өргөжсөн байна. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамтай (ССАЖЗЯ) байгуулсан гэрээний дагуу төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын аялал жуулчлалын салбарын бодит төлөөллийг бүрдүүлсэн, нэгдсэн зохион байгуулалт бүхий институтын тогтолцоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.



ЭРХЭМ ЗОРИЛГО

Монгол Улсын аялал жуулчлалын салбарт үндэсний онцлог, нүүдлийн соёлд тулгуурласан тогтвортой хөгжлийг дэмжих, салбарын мэргэжлийн стандарт, үйлчилгээний чанар, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, төр, хувийн хэвшил, орон нутгийн байгууллагуудын уялдаа холбоо, хамтын ажиллагааг бэхжүүлэх, улмаар Монгол Улсын аялал жуулчлалын брэндийг олон улсад таниулж, эдийн засгийн бодит үр өгөөжийг нэмэгдүүлэхэд манлайлан оролцох.


АЛСЫН ХАРАА

Монгол Улсын аялал жуулчлалын салбарын

- Хуульд суурилсан засаглалын жишиг байгууллага
- Төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааны үндэсний платформ
- Олон улсын зах зээлд Монголын аялал жуулчлалыг төлөөлөх мэргэжлийн институт
- Хүний нөөц, стандарт, инновац, тогтвортой хөгжлийн төв болон төлөвшиж, бүс нутагтаа өрсөлдөх чадвартай, хариуцлагатай аялал жуулчлалын хөгжлийг хөтөлгөч байгууллага байна.

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН ХОЛБООНЫ БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ БА УДИРДЛАГА

Аялал Жуулчлалын Мэргэжлийн Холбоо (НЭЗХЭ)-ийн “Нэгдсэн дүрэм”-ийн 3 дугаар бүлгийн 14 дүгээр зүйлд заасны дагуу дараах бүтэц, зохион байгуулалтаар үйл ажиллагаа явуулж байна. Холбоо нь гишүүдийн оролцоонд тулгуурласан, ил тод, хариуцлагатай удирдлагын тогтолцоотой бөгөөд салбарын бодлого, зохицуулалт, хамтын ажиллагааг уялдуулан хэрэгжүүлэх чиг үүрэгтэй ажилладаг.



“АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН ХОЛБОО” НД ЭЛСЭЖ ГИШҮҮНЧЛЭЛТЭЙ БОЛОХ НЬ ЯАГААД БИЗНЕСИЙН ХУВЬД ЗӨВ ШИЙДВЭР ВЭ?

Аялал жуулчлалын салбар 2023 оноос Аялал жуулчлалыг дэмжих жилүүдийн хүрээнд өөрсдийн бодлого, стандарт, бүртгэл, баталгаажуулалт дээр тулгуурласан нээлттэй, хялбар аргаар мэдүүлдэг, нэгдсэн цонхны үйлчилгээ бүхий зохион байгуулалттай тогтолцоонд шилжиж байна.

Тухайлбал:

1. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРЫН БОДЛОГО, ШИЙДВЭРТ НӨЛӨӨЛӨХ, ЭРХ АШГИЙГ ТАНЬ ХАМГААЛАХАД ТУСАЛНА.

Аялал Жуулчлалын Мэргэжлийн Холбоо нь (НЭЗХЭ) статустай салбарын мэргэжлийн байгууллага юм. Аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн төсөл, уг хуулийг даган гарах журмуудын хэлэлцүүлэг, мөн визний бодлогын хөнгөлөлт, хил орчмын маршрутын баталгаажуулалт, татварын хөнгөлөлт, хөнгөлөлттэй зээлийн нөхцөл, аялал жуулчлалын бүсэд хөрөнгө оруулалт хийх, хүний нөөцийн бодлогыг боловсруулах, татах, хөгжүүлэх зэрэг салбарын томоохон асуудлуудад гишүүнчлэлийн хүрээнд оролцож саналаа өгч байна.

Мөн манай гишүүн байгууллага болсноор хурдан шуурхай мэдээлэл авч, ажлын хэсэгт орж ажиллах, саналаа нэгтгэх, хэлэлцүүлэх бодлогын хэлэлцүүлэгт орж асуудлаа бодитоор тавих, шийдүүлэх боломж бололцоог нэмэгдүүлж байна. Энэ нь ганцаарчилсан санал гаргахаас илүү хүчтэй шийдэлтэй, нөлөөтэй механизм юм.

2. АЛБАН ЁСНЫ БҮРТГЭЛТЭЙ БАЙГУУЛЛАГА ГЭДГИЙГ ТАНЬ БАТАЛЖ ТӨРӨӨС БОЛОН БУСАД БАЙГУУЛЛАГААС ХӨНГӨЛӨЛТ УРАМШУУЛАЛ АВАХАД ТАНЬ ТАНЫ БИЗНЕСИЙГ БАТАЛГААЖУУЛЖ ӨГНӨ.

Тур операторуудын QR бүртгэл нь зүгээр нэг жагсаалт биш. Энэ бүртгэл нь:

- НӨАТ-ын чөлөөлөлтийн үндэслэл
- ААНОАТатвараас 2023 оны 6 дугаар сарын 1-нээс 2026 оны 12 сарын 31-ныг дуустал орлогыг чөлөөлүүлнэ.
- Визний зөвшөөрөл авахад үйл ажиллагааг чинь нотолно.
- Хил орчмын хамтын ажиллагааны гэрээ байгуулах нөхцөл зэрэг төрийн үйлчилгээ авах эрх зүйн баталгаанд ашиглагдаж байна.

Өнөөдрийн байдлаар 400 гаруй тур оператор нэгдсэн

бүртгэлд хамрагдсан нь систем бодитоор хэрэгжиж байгааг харуулж байна.

3. ОЛОН УЛСЫН СТАНДАРТАД НИЙЦСЭН БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ БОЛОХОД ТУСАЛЖ, ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЧИНЬ БАТАЛГААЖУУЛЖ ӨГНӨ.

- Зочид буудал, жуулчны бааз, аялал жуулчлалын цогцолборын ангилал зэрэглэлийг зохион байгуулж одны зэрэглэлийг олгоно.
- Жуулчны хөтөч тайлбарлагчийн мэргэжлийн албан ёсны үнэмлэхийг олгоно.
- Жуулчин тээврийн үйлчилгээ үзүүлэгч иргэнд “TOURIST” наалт баталгаажуулалтыг хэрэгжүүлнэ.
- Тусгай сонирхлын хөтөч тайлбарлагчийн үнэмлэх, зэрэглэл олгоно.
- НИТАЖ ын бүртгэлийг хөтөлнө.

Одоогоор:

- 150 гаруй жуулчны хөтөч тайлбарлагч албан ёсны үнэмлэхтэй болсон.
 - 500 гаруй жолооч 12 жилээс дээш жил, буруу рультэй тул нэгдсэн бүртгэлд орж сургалтад хамрагдсан.
 - 1000 гаруй аж ахуйн нэгж байгууллага, иргэний бизнесийн үйл ажиллагааны талаарх албан ёсны мэдээлэл нэгдсэн системд орсон байна.
- Эдгээр нь гадаад түншүүд, жуулчдад албан ёсны, баталгаатай, итгэл даахуйц байгууллагын статусыг нь илэрхийлж өгдөг.



4. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖҮҮЛЭЛТ, ГАДААД ДАХ СУРТАЛЧИЛГАА, ЭЭРЭГ СЭТГЭГДЭЛТЭЙ БОЛОХОД ТАНЬ ТУСАЛНА.

“Go Mongolia” үндэсний санаачилгын хүрээнд нислэгийн давтамж нэмэгдэж, агаараар 500,000 орчим жуулчин хүлээн авах боломж бүрдсэн. Солонгос, Хятад, Европ, Япон, АНУ, Адал явдалт аяллын зах зээлийг кластер хэлбэрээр хөгжүүлэх ажлууд эхэлж, соёлын эвент календариуд тогтмолжиж, Монгол улсаас гадаад улсад суух элчин сайдын яамдаар дамжин сурталчилгаа хийгдэж байна.

Гишүүнээр элсэж өөрийн голлох зах зээлийн холбоодод тур операторууд нэгдсэнээр гадаад зах зээл дээр мэдээлэл, хамтын ажиллагаа, B2B уулзалт, олон улсын хамтын ажиллагаануудад оролцох боломжтой байдаг. Тухайлбал олон улсын нэр хүнд бүхий ITB Berlin, WTM Лондон, JATA, SITF Сөүл, COTTM Шанхай, CITM Шанхай, TOP RE3A Парис, LET'S TRAVEL Москвад тогтмол оролцдог болсноос гадна шинээр Хонг Конг, Вьетнам, Сингапур, Тайланд зэрэг зүүн өмнөд азийн орнууд руу чиглэсэн рөүд шоу, фам тур зэрэгт хамрагдах боломж нээгддэг.



5. ИЛ ТОД, ГИШҮҮНДЭЭ СУУРИЛСАН ТОГТОЛЦООГ НЭВТРҮҮЛСЭН.

АЖМХолбооны эрх барих дээд байгууллага болох Нэгдсэн хуралдаан нь жил бүр хуралдаж тайлангаа гишүүдэд хүргэдэг бөгөөд олон нийт болон төрийн байгууллагад хуулийн хугацаанд тайлангаа хүргэж ажиллаж байна. Тус холбооны www.mto.mn цахим хуудасны тайлан цэсэнд жил бүрийн үйл ажиллагаа болон санхүү, аудитын тайлангууд байршдаг юм. Энэ нь ил тод нээлттэй систем хэрэгжүүлж байгаа үлгэр жишээ байгууллага болж төлөвшихөд эерэгээр нөлөөлж байна.

Мөн Удирдах зөвлөлийн зүгээс ажлын албаны жилийн төсөв санхүү, бүтцийг баталж чиг үүргийн хороод, салбар холбоодтой нягт хамтран ажиллаж байгаа нь өөрөө өөрийгөө удирддаг гишүүнчлэлд суурилсан системийг бүрэн бүрдүүлэх нөхцлийг бий болгож байна. Энэ нь гишүүдийн татварын зарцуулалт, төрийн зарим чиг үүргийг гүйцэтгэсэн төсөв санхүүжилтийн тайланд саналаа өгөх, хянахад онцгой ач холбогдолтой тогтолцоо юм.

6. ТАНЫ БИЗНЕСИЙН ТАЛААРХ КОНТЕНТ, ОЛОН НИЙТЭД ХҮРСЭН БАЙДЛЫГ ӨСГӨХӨД ХУВЬ НЭМРЭЭ ОРУУЛНА.

2025 оны байдлаар АЖМХолбооны нэгдсэн контент бодлогын хэрэгжилтийн үр дүнд дижитал сувгуудын гүйцэтгэл мэдэгдэхүйц өсөлт үзүүлэв. Энэ нь аялал жуулчлалын салбарт бизнес эрхлэгчид болон зорилтот хэрэглэгчдэд мэдээлэл өгөх хурд болон үзэлт хандалт өндөр байгааг харуулж байна. Энэ нь таны өөрийн бизнесээ сурталчлах, төрийн болон орон нутгийн мөн мэргэжлийн байгууллагуудтай харилцаа холбоо үүсгэх, шинэ хамтрагчтай болж ашиг орлогоо нэмэгдүүлэх нөхцөл бололцоог хангаж чадахуйц өргөн сүлжээг бий болгосон байна.

- Нийт үзэлт: 7,900,000+
- Контент харилцан үйлдэл: 108,600 (194.4%-ийн өсөлт)
- Линк даралт: 8,600 (64%-ийн өсөлт)
- Хуудасны хандалт: 212,600 (30.1%-ийн өсөлт)



7712 8822



info@mto.mn



www.mto.mn

ГИШҮҮНЧЛЭЛ 2025



АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МЭРГЭЖЛИЙН ХОЛБООНЫ ГИШҮҮНЧЛЭЛ, САЛБАРЫН ТӨЛӨӨЛӨЛ

2025 оны байдлаар Аялал Жуулчлалын Мэргэжлийн Холбоо (АЖМХ) нь салбарын нэгдсэн бодлого, мэргэжлийн төлөөллийг ханган ажилладаг үндэсний хэмжээний бүтэц бүхий байгууллага болон хөгжиж байна. Тус холбоо нь 12 бүрэн эрхт, 5 хязгаарлагдмал эрхт салбар холбоо, нийт 400 гаруй гишүүн байгууллагыг нэгтгэн, аялал жуулчлалын салбарын олон талт оролцогчдыг хамарсан төлөөллийн тогтолцоог бүрдүүлээд байна. Салбар холбоод нь зах зээлийн чиглэл, бүс нутгийн онцлог, мэргэжлийн төрөлжсөн чиг үүргийн дагуу зохион байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд орон нутгийн оролцоог нэмэгдүүлэх, бүсчилсэн хөгжлийг дэмжих зорилтын хүрээнд 5 аймагт салбар холбоо байгуулагдаад байна. Мөн 2 аймагт салбар холбоо байгуулах бэлтгэл ажил хангагдаж, материал бүрдүүлэлтийн шатанд үргэлжилж байна.

Бүрэн эрхт салбар холбоод:

- Хятад зах зээлийн салбар холбоо
- Жуулчны бааз, Байршуулах хэрэгслийн салбар холбоо
- "Америк Монголын Аялал Жуулчлалын Хөгжлийн Тэгш Нийгэмлэг" ТББ
- Эртний нүүдэлчдийн өлгий Архангай аймгийн аялал жуулчлалын холбоо
- Европ Зах Зээлийн Салбар Холбоо
- Монгол Солонгосын Зах Зээлийн Аялал Жуулчлалын Холбоо
- "Төв Аймгийн Аялал Жуулчлалын Холбоо" ТББ
- "Монголын Мэргэжлийн Хөтөч Тайлбарлагчийн Холбоо" ТББ
- Аялал Жуулчлалын Боловсрол Хөгжлийн Нийгэмлэг
- Дорноговь Аймгийн Аялал Жуулчлалын Холбоо
- Монголын Жуулчин Тээврийн Холбоо
- Гадаад Аяллын Салбар Холбоо

Хязгаарлагдмал эрхт салбар холбоод:

- Монгол Японы Аялал Жуулчлалын Салбар Холбоо
- Адал Явдалт, Тусгай Сонирхлын Аялал Жуулчлалын Мэргэжлийн Холбоо
- Булган аймгийн аялал жуулчлалын холбоо
- Сэлэнгэ аймгийн аялал жуулчлалын "ТАВАН ХАН" ТББ
- НИТАЖ эрхлэгчдийн салбар холбоо

Олон улсын зах зээл дэх гүйцэтгэл

2024–2025 онд АЖМХ нь Монгол Улсыг төлөөлөн TEJ Nagoya (13 компани), WTM London (10 компани), USTOA ANU (5 компани), CITM Naikou BNХАУ (10–12 компани) зэрэг олон улсын томоохон үзэсгэлэн, форумуудад оролцон, үндэсний компаниудын оролцоог зохион байгуулалтаар ханган ажиллав.



САЛБАР ХОЛБООД



Монголын Солонгос зах зээлийн аялал жуулчлалын холбоо

kmongolia.tours@gmail.com



Хятад зах зээлийн салбар холбоо

chinamarketorg@gmail.com



Монгол Японы аялал жуулчлалын холбоо

info.mjta@gmail.com



Гадаад аяллын салбар холбоо

outbound@mto.mn



Аялал жуулчлалын боловсрол хөгжлийн нийгэмлэг

tourism.research.mon@gmail.com



Жуулчны бааз, байршуулах хэрэгслийн салбар холбоо

touristcamps.mto@gmail.com



"Эртний нүүдэлчдийн өлгий" Архангай аймгийн аялал жуулчлалын холбоо

arkhangaitourism@gmail.com



Төв аймгийн аялал жуулчлалын холбоо

branch@mto.mn



Америк Монголын аялал жуулчлалын хөгжлийн тэгш нийгэмлэг

tourismallianceamta@gmail.com



НИТАЖ эрхлэгчдийн салбар холбоо

branch@mto.mn



Монголын мэргэжлийн хөтөч тайлбарлагчийн холбоо

info@mptga.org



Дорноговь Аймгийн Аялал Жуулчлалын Холбоо

dornogovi.mto@gmail.com



Адал явдалт аялал жуулчлалын мэргэжлийн холбоо

mata.ngo.mgl@gmail.com



Европ зах зээлийн салбар холбоо

eumarket@mto.mn



"Булган Хангай" Булган аймгийн аялал жуулчлалын холбоо

branch@mto.mn



Монголын жуулчин тээврийн холбоо

juulchinteever@gmail.com



Сэлэнгэ аймаг дахь Аялал жуулчлалын "ТАВАН ХАН" ТББ салбар холбоо



МОНГОЛЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРЫН ХӨГЖЛИЙН ХӨДӨЛГӨГЧ ХҮЧ БА ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГОЛ ХААЛГА

Монгол Улсад жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Аялал жуулчлалын долоо хоног (TOURISM WEEK)” нь салбарын бодлого, шинэ бүтээгдэхүүн, олон улсын хамтын ажиллагааг нэгтгэсэн томоохон платформуос гадна гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах салбарын гол арга хэмжээ болон өргөжөөд байна.

Цар тахлын дараах сэргэлтийн жилүүд болох 2024–2025 онуудад уг арга хэмжээ нь салбарын хөгжилд бодит түлхэц өгч, Монголын аялал жуулчлал дэлхийд өрсөлдөх чадвар нэмэгдсэнийг харуулсан.

Монголын аялал жуулчлалын бодит өсөлт ба хөрөнгө оруулагчдын сонирхол

2024–2025 оны эерэг үзүүлэлтүүд нь салбар руу чиглэсэн хөрөнгө оруулалтыг идэвхжүүлэх гол үндэслэл болсон:

- 2024 онд: 808,956 жуулчин
- Өвлийн аялал: 35% өссөн
- Дундаж зарцуулалт: 980 ам.доллар
- “Go Mongolia 2.0” шинэ брэнд олон улсад танигдсан
- Ази, Европ, Зүүн өмнөд Азийн гол операторуудад Монголын брэнд хүрсэн

Эдгээр өсөлттэй зэрэгцэн хөрөнгө оруулалтын урсгал эрс нэмэгдэж, аялал жуулчлалын долоо хоногийг салбарын “инвестор төвтэй арга хэмжээ” болгох шаардлага бий болсон бөгөөд Монгол Улс үүнийг амжилттай хэрэгжүүлж эхэлжээ.

TOURISM WEEK — Хөрөнгө оруулагчдыг татах хамгийн том жилийн эвент

Өмнөх жилүүдийн тайлангаас харахад TOURISM WEEK нь дараах онцгой үүргийг биелүүлдэг. Үүнд:

1. Олон улсын хөрөнгө оруулалтын форумын талбар Хөтөлбөрт:

- Дэлхийн аялал жуулчлалын байгууллагууд
 - Ази, Европын топ тур операторууд
 - Их сургууль, судалгааны байгууллагууд
 - Санхүүгийн институци, хөгжлийн агентлагууд
- гадаадын хөрөнгө оруулалтын боломжийг сонирхож, Монголын аялал жуулчлалын экосистемийг судлах зорилгоор оролцдог.

2. Аймаг–хотын хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн танилцуулах боломж

21 аймаг өөрийн:

- Байгалийн аяллын цогцолбор
- Амралтын газрын шинэ төсөл
- Дэд бүтцийн шаардлага
- Инвестор хайж буй бүтээгдэхүүнүүд зэрэг мэдээллээ нэг тайзан дээр танилцуулдаг.

3. Салбарын хөрөнгө оруулалтын чиг хандлагыг тодорхойлдог

Аялал жуулчлалын долоо хоног нь сүүлийн жилүүдэд салбарын хөрөнгө оруулалтын стратегийн барометр болжээ.

Хөрөнгө оруулагчид Монголын аялал жуулчлалын боломжийг судлахдаа энэ долоо хоногийг онцгойлон анхаарч ач холбогдол өгч оролцоо нэмэгдэж байна.



7712 8822



info@mto.mn



www.tourismweek.mn

2026 ОНООС “TOURISM WEEK” ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНД ТЭЛЖ, САЛБАРЫН БРЭНД АРГА ХЭМЖЭЭ БОЛНО



2026 оны арга хэмжээг шинэчлэн зохион байгуулснаар дараахь зорилтот ажлыг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Олон улсын бизнес–matching систем нэвтрүүлнэ:



Аяллын бүтээгдэхүүн → Гадаад оператор → Эко ресорт → Хөрөнгө оруулагч → Аймгууд → Дэмжлэгийн сангууд гэсэн matchmaking платформ ажиллана.

2. “GO MONGOLIA” – Инвестор SUMMIT зохион байгуулагдана. Энэ бол салбарын хамгийн том B2B уулзалт болно.

“TOURISM WEEK-2026” ҮНДЭСНИЙ ЧУУЛГАНЫ ИЛГЭГЧИД



Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам болон Аялал Жуулчлалын Мэргэжлийн Холбоо (Mongolia Tourism Organization) хамтран зохион байгуулж буй “Tourism Week-2026” арга хэмжээ 2026 оны 03 дугаар сарын 09-15-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулагдана.

Өнгөрсөн жил салбарын 1000 гаруй төлөөлөл оролцсон бол, энэ жил The United Nations World Tourism Organization (UNWTO), JICA, KOICA, Korean tourism organizations, The nature conservancy зэрэг олон улсын нэр хүндтэй байгууллагуудын үндсэн илтгэгчид, мөн гадны хөрөнгө оруулагчид Монголд чуулна. Tourism Week 2026 хамтын ажиллагаа бодит боломж болж, аялал жуулчлалын төлөвлөлтийг хамтдаа хийцгээе.



7712 8822



info@mto.mn



<https://tourismweek.mn/>

TOURISM WEEK 2026
MR. TAKAHIKO MAKINO
JICA Expert for Sustainable Tourism Development Project

ИЛТГЭЛИЙН СЭДЭВ:
JICA-ийн төсөл, Тогтвортой аялал жуулчлалын эвслэлийн гурав тэмцээнийг
JICA төслийн танилцуулга, семинарын зохиого, тайлбар

2026.03.01 | Улаанбаатар хотноо

TOURISM WEEK 2026
MR. KAZUHIRO ARAI
Founder of the Daisetsuzan Nature School

ИЛТГЭЛИЙН СЭДЭВ: Тогтвортой аялал жуулчлалын олон улсын шалгуур ба гэрчилгээжүүлэх тогтолцоо

2026.03.02 | Улаанбаатар хотноо

TOURISM WEEK 2026
С.ТУУЛ
Найслэлийн Аялал жуулчлалын газрын Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга

ИЛТГЭЛИЙН СЭДЭВ: 2026 онд Улаанбаатар хотод аялал жуулчлалын чиглэлээр хийгдэх ажлууд

2026.03.03 | Улаанбаатар хотноо

TOURISM WEEK 2026
MR. KENSUKE MIYAGI
CHIEF REPRESENTATIVE, JICA MONGOLIA OFFICE

2026.03.04 | Улаанбаатар хотноо

TOURISM WEEK 2026
Э.НОМИНДАРЬ
"Монголын байгалийн өв рол" -ийн Гүйцэтгэх захирал

ИЛТГЭЛИЙН СЭДЭВ: Байгальд ээлтэй аялал жуулчлал болон санхүүжилтийн боломжууд

2026.03.05 | Улаанбаатар хотноо

TOURISM WEEK 2026
HWABONG LEE PHD
ВНКО-ын Хэлэлцэх Мэ Сургуулийн Стратегийн хариуцаан захирал

ИЛТГЭЛИЙН СЭДЭВ: Very Mongolian Mice and It's Tourism

2026.03.06 | Улаанбаатар хотноо

TOURISM WEEK 2026
MR. YUXIN YIN
Chairman, Head of the Mongolia National Pavilion at the SCO (Shanghai Cooperation Organization) Demonstration zone

ИЛТГЭЛИЙН СЭДЭВ: Аялал жуулчлалын хөгжил Олон улсын худалдаанд үзүүлэх нөлөө

2026.03.08 | Улаанбаатар хотноо

TOURISM WEEK 2026
МИНЖИ КИМ
ВНСУ-ын илтгэн (Professional Conference Organizer) PCO (Энхэржлийн туршиж зохион байгуулагч)

ИЛТГЭЛИЙН СЭДЭВ: Олон улсын жуулчлал, форумийг мэргэжлийн түвшинд зохион байгуулах практик аргачлал

2026.03.09 | Улаанбаатар хотноо

TOURISM WEEK 2026
Э.БИЛГҮҮН
Get Airport Taxi / USB Shuttle" үүсгэн байгуулагч

ИЛТГЭЛИЙН СЭДЭВ: Олон улсын зах зээлд нэг сегментээр өрсөлдөх боломж

2026.03.10 | Улаанбаатар хотноо



7712 8822



info@mto.mn



<https://tourismweek.mn/>



2026

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХУАНЛИ

- 2026.01.31-02.01 "УЛААНБААТАР" ӨВЛИЙН НААДАМ
- 2026.02.28-03.01 "УЛААНБААТАР" ӨВЛИЙН ЯВГАН АЛХАЛТЫН ӨДРҮҮД
- 2026.03.07-08 БҮРГЭДИЙН БАЯР
- 2026.03.22 НАРНЫ БАЯР /НАУРЫЗЫН БАЯР/
- 2026.05.08-10 "ПОВЕР ЭКСПО" АВТО УРАЛДААН
- 2026.05.31 БУРХАН БАГШИЙН ИХ ДҮЙЧИН ӨДӨР
- 2026.06.06-07 "ТАЛЫН САЛХИ" ОЛОН УЛСЫН МОТО НААДАМ
- 2026.06.12-14 "ТЭНГЭР" БӨӨГИЙН НААДАМ
- 2026.06.20 "РЭГГИ" ХӨГЖМИЙН НААДАМ
- 2026.06.27-28 НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТЫН ИРГЭДИЙН ӨДӨР "ХҮРЭЭ ЦАМ-ДАНШИГ НААДАМ"
- 2026.07.02-04 "ПЛЭЙТАЙМ" ОЛОН УЛСЫН ХӨГЖМИЙН НААДАМ
- 2026.07.09 "ДЭЭЛТЭЙ МОНГОЛ" НААДАМ
- 2026.08.06-09 "УБ ФҮҮД" ОЛОН УЛСЫН ХООЛНЫ ӨДРҮҮД
- 2026.08.28-30 "УЛААНБААТАР" ОЛОН УЛСЫН ЯВГАН АЛХАЛТЫН ӨДРҮҮД
- 2026.09.05-06 "МЯНГАН МОРЬТОН" НААДАМ
- 2026.09.05-06 "ХИЙМОРЬ" МОРЬТ ХАРВААНЫ ОЛОН УЛСЫН ТЭМЦЭЭН
- 2026.09.05-10 ОЛОН УЛСЫН ФОТО ЗУРГИЙН НААДАМ

ЭРХЛЭГЧИЙН ЗУРВАС

Монгол орны өвөл бол үгээр илэрхийлэхийн аргагүй гайхамшиг, байгалийн хосгүй үзэсгэлэн билээ. Энэ гайхамшгийг дэлхийн жуулчдад таниулах цаг нэгэнт иржээ.

Саяхан “Physical Asia” нэвтрүүлэгт манай баг тамирчдын үзүүлсэн амжилт дэлхийн олон сая үзэгчдийн анхаарал, талархлыг татаж, Монгол Улсын нэрийг өндөрт өргөсөн түүхэн үйл явдал боллоо. Энэ амжилтын дараагаар Монголын тухай олон улсын контентууд, аялал жуулчлалын шинэ давалгаа ар араасаа гарч ирэх нь тодорхой болсон байна.

Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэхийн тулд манай улсын зочлох үйлчилгээний салбар цахилгаан эрчим хүч, дулаан хангамжийн асуудлаа бодитоор шийдвэрлэх шаардлагатай. Энэ хүрээнд салбарын сайд Чинбатын Ундрам онцгой ач холбогдол бүхий шийдвэр гарган, улсын төсөвт анх удаа аялал жуулчлалын салбарт 150 тэрбум төгрөгийн жилийн 6%-ийн хөнгөлөлттэй зээлийг суулгасан нь салбарынхандаа бодит дэмжлэг болсон чухал алхам байлаа. Жилийн дөрвөн улирал тогтвортой үйл ажиллагаа явуулах бэлтгэлийг хангах, ялангуяа жуулчны баазууд цахилгаан дулааны асуудлаа байгальд ээлтэй ногоон эрчим хүчээр шийдэх боломж нээгдэж буй нь тэмдэглүүштэй сайн мэдээ юм.

Шинэ оноо угтаж буй энэ сайхан өдөр аялал жуулчлалын салбарынхандаа энэхүү шинэ боломжийн талаар баярт мэдээ хүргэж та бүхэнд аз жаргал, урам зориг бэлэглээсэй хэмээн хүсэж мэндчилж байна.

Мөн нэгэн сонирхолтой мэдээ дуулгахад, Монгол–Солонгосын анхны албан ёсоор хамтарсан продакшн гэрээгээр **“CO-PRODUCTION CONTRACT”** “бүтээгдсэн **“SNOW. JUNE** – 6 сарын цас” бүрэн хэмжээний уран сайхны кино энэ жил Монгол улсад зураг авалтаа хийж дууслаа. 2026 онд БНСУ-ын кино театруудаар нээлтээ хийхээр төлөвлөгдөж байна. Энэхүү кино нь Монгол Улсыг олон улсад эерэг имижтэйгээр сурталчлах дараагийн томоохон төслүүдийн нэг болж, шинэ давалгааг эхлүүлэх нь гарцаагүй юм. Түүнчлэн уг бүтээлийн санаачилгыг FOUR SEASONS сэтгүүлийн редакцын зүгээс гаргаж хоёр улсын мэргэжлийн томоохон кино компаниуд хөрөнгө оруулалт хийж дэмжсэнээр амжилттай бүтээгдсэнг дурдахад таатай байна.

Ингээд баяр баясал, аз жаргалыг бэлгэдсэн шинэ жил айсуй энэ үед өв соёлоо мэдэрч, Монголын гайхамшигт өвлийн шөнийн уран гоо үзэмж дунд тогтвортой эрчим хүч, халуун дулаан орчинд мартагдашгүй сайхан дурсамж бүтээхийг хүсэн ерөөе. Тогтвортой аз жаргалтай сайн цаг айсуй.

Таныг хүндэтгэсэн,
Эрхлэгч:
С.Болорбайгаль



TOURISM WEEK FOUR SEASONS MAGAZINE

is published biseasonly by FOUR SEASONS Magazine
Khan-Uul District, Zaisan
Tel: +976 99995010, +976 80800709
Web: www.fourseasons.mn

Publisher: Bolorbaigali Sukhbaatar Gegeenten
Edited & Designed by Four Seasons Design
Department
Editor-In-Chief G.Ariunzul
Design Director: Altanbagana.P
Editor: Mongolia Tourism Organization
English section editor: G.Ariunzul & Content team
Journalist: B.Enkhtsetseg, Ts.Myagmarsuren
P.Munkhjargal
Office: info@fourseasons.mn
Marketing department:
fourseasonsmongolia@gmail.com

Disclaimer: The contents provided by clients
under a commercial arrangement are not the
responsibility of Four Seasons magazine.

Platform partner: All-in-Mongolia
Technology partner: ERXES LLC





ЦӨЛЖИЛТ, ГАЗРЫН ДОРОЙТОЛТТОЙ ТЭМЦЭХ ДЭЛХИЙН ХУРАЛ МОНГОЛД АНХ УДАА

COP17 УЛС ОРНУУДЫН АНХААРЛЫГ ТАТНА

Монгол Улс цөлжилт, газрын доройтол, гантай тэмцэх олон улсын хамтын ажиллагааны манлайллыг хүлээн авсан. Энэхүү ажлын хүрээнд "Цөлжилттэй тэмцэх тухай" НҮБ-ын Конвенцын Талуудын 17 дугаар бага хурал (COP17)-ыг 2026 оны 8 дугаар сарын 17–28 нд Улаанбаатар хотод зохион байгуулах гэж байна. Энэ шийдвэр нь Монгол Улсын байгаль хамгаалал, уур амьсгалын бодлогын чиглэлд өрнүүлж буй шинэчлэл, амжилтыг олон улсын тавцанд харуулах түүхэн боломж билээ.

Дэлхийн хуурай газрын ойролцоогоор 40 хувь нь цөлжилт, газрын доройтолд өртсөн нь хүнсний аюулгүй байдал, усны нөөц, нийгэм-эдийн засагт ноцтой аюул занал учруулж байна. Монгол Улсад нийт газар нутгийн 77 хувь нь ямар нэг хэмжээгээр доройтолд өртөж, бэлчээр талхагдах, ой модны хомсдох, хөрсний доройтол нэмэгдэх зэрэг сорилтууд малчдын амьжиргаа, бүс нутгийн тогтвортой байдалд шууд заналхийлж байна. Иймд COP17 хурлыг Монголд хүлээн авч зохион байгуулах нь зөвхөн нэр төр төдийгүй дэлхий нийтэд бодит туршлага, практик шийдлээ хуваалцах үйл явц болох юм.

Уг арга хэмжээнд "Аялал Жуулчлалын Мэргэжлийн Холбоо" (MONGOLIA TOURISM ORGANIZATION) нь зочид буудал, байршуулах хэрэгслийн судалгааг гаргаж, зочдын буудаллах газар, өдрийн аяллыг зохион байгуулах, менежментийг хариуцан ажиллаж байна.



Монгол Улс сүүлийн жилүүдэд "Тэрбум мод" хөтөлбөрийн хүрээнд өргөн хүрээний ойжуулалт, экосистем сэргээх үндэсний аян хэрэгжүүлж, бэлчээрийн менежмент, газар ашиглалтын шинэ загваруудыг туршиж байна. Эдгээр санаачилгууд нь Конвенцын зорилтуудтай нийцэж, байгальд ээлтэй, дасан зохицсон практик шийдлийг олон орны туршлагатай холбох үнэ цэнтэй боломжийг бүрдүүлнэ.

COP17 нь зөвхөн төр засгийн түвшний хэлэлцүүлэг биш — хувийн хэвшил, шинжлэх ухаан, иргэний нийгмийн байгууллага, залуучууд, олон улсын түншлэлийн өргөн хүрээний оролцоог нэгтгэнэ. Хурлын үндсэн хэлэлцэх чиглэлүүдэд газрын доройтлыг тэглэх бодлого, ногоон технологийн шийдэл, дасан зохицсон бэлчээр, мал аж ахуйн оновчтой загварууд, ногоон санхүүжилт ба орон нутгийн тогтвортой хөгжил, залуучууд, иргэний нийгмийн оролцоог идэвхжүүлэх санаачилгууд зэрэг багтаж байна. Эдгээр хэлэлцүүлэг нь экологийн шинэ санаа, инновац, ногоон хөрөнгө оруулалтын боломжийг татаж, цөлжилттэй тэмцэх олон талт арга замыг оновчтой болгох зорилготой.

Монгол орны онцлог болох өргөн талбай, нүүдэлчин соёлын байгальд зохицсон уламжлалт мэдлэг, бэлчээрийн удирдлагын практик нь олон улсад хэрэгжүүлэхэд тохиромжтой кейс юм. COP17-ын үеэр Монголын туршлага, ногоон шийдэл дэлхийд танилцуулагдаж, талууд амьдралд суурилсан, шинжлэх ухаан, технологитой уялдсан бодит алхмуудыг хуваалцах боломжтой. Мөн хурлын зохион байгуулалт болох Улаанбаатар хотыг бүс нутгийн уур амьсгал, экологийн асуудлыг хэлэлцэх дипломат, шинжлэх ухаан, инновацийн төв болгоход хувь нэмэр оруулах үйл явдал болох юм.

COP17 хурлаас хүлээгдэж буй үр дүн нь Монгол Улсын ногоон хөгжлийн бодлогыг олон улсад сурталчилах, шинжлэх ухаан, технологи, аялал жуулчлалын салбар дахь хамтын ажиллагааг өргөжүүлэх, олон улсын ногоон хөрөнгө оруулалтыг татах, байгаль хамгааллын манлайллыг бататгахад чиглэнэ. Уг бага хурлын үеэр Монгол Улс нүүдэлчин ард түмний байгальд зохицсон уламжлалт мэдлэг, практикийг дэлхий нийтэд таниулж, "Цөлжилт, газрын доройтолтой тэмцэх нь зөвхөн байгаль хамгаалах бус хүн төрөлхтний ирээдүйг хамгаалах үйлс" гэдгийг тодорхой илэрхийлэх болно.

Road to COP17

On February 21, 2025 the Government of Mongolia and the United Nations Convention to Combat Desertification (UNCCD) signed an agreement paving the way for the 17th session of the Convention's Conference of the Parties (COP17) in Ulaanbaatar in 2026.

COP17 will bring together UNCCD's 197 Parties in a crucial global forum to accelerate action against desertification, land degradation and drought. As one of the most affected countries by desertification, with nearly 77 per cent of its land degraded, Mongolia will leverage COP17 to drive solutions for land restoration, sustainable land management and resilience-building across the world.

COP17, set for 2026 during the International Year of Rangelands and Pastoralists (IYRP) — declared by the United Nations General Assembly and championed by Mongolia — will build on efforts to promote the sustainable management, restoration and conservation of rangelands.



COP17 Зохион байгуулах Үндэсний хороо



www.unccdcop17.org



НҮҮДЭЛЧИН — ДЭЛХИЙН СОЁЛЫН НААДАМ

Монголын аялал жуулчлалын голлох брэнд эвент, жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг дэлхийн хэмжээний фестиваль

Монголын нүүдлийн соёлыг дэлхийд таниулах хамгийн том олон улсын арга хэмжээ болох “Нүүдэлчин – Дэлхийн соёлын наадам” жил бүр Монгол Улсад зохион байгуулагдаж, Монголын аялал жуулчлалын голлох брэнд эвентүүдийн нэг болон бэхжиж байна. Тайж хайрханы бэлд болдог энэ наадам нь монгол ахуй, нүүдлийн уламжлал, морин спорт, язгуур урлаг, утга соёлын гайхамшгийг нэг дор цогцлоосон соёлын цогц фестиваль юм.

Энэ жилийн наадамд Монголын нүүдлийн уламжлалт амьдрал, адууны соёл, язгуур урлаг, гэр ахуйн соёл бүрдүүлэлт, хүүхдийн соёл боловсролын үндэсний тоглоомууд хүртэл багтсан 100 гаруй үзүүлбэр, 30+ орны зочид, хэдэн арван мянган аялагч, жуулчид оролцдог болоод байна.

2025 оны наадмын хамгийн онцлох хэсгүүд нь морин спортын ёслол, адуу тамгалах зан үйл, сур харвалт, бөхийн барилдаан, өвөрмөц айл өрхийн ахуй харуулсан үзүүлбэрүүд нь жуулчдын анхаарлыг хамгийн их татсан хөтөлбөрүүдийн нэг болсон юм.

Наадам хоёр өдрийн турш цахим орчинд нийт 10 гаруй сая хүнд хүрч, олон улсын хэвлэлүүд Монголын соёлыг онцлон мэдээлсэн нь Монгол Улсыг “НҮҮДЛИЙН СОЁЛЫН ГОЛОМТ” хэмээн дэлхийд дахин тодруулсан үйл явдал болов. Орон нутгийн аялал жуулчлалын бизнест бодит хөшүүрэг болж, худалдаа, үйлчилгээ, жуулчны баазуудын ачааллыг огцом өсгөсөн нь эдийн засгийн хүртээмжийг өргөн хүрээнд бий болгожээ.

2026.08.22-24
УЛААНБААТАР ХОТ



Нүүдэлчин дэлхийн соёлын фестиваль



nomads_world_cultural_fest

Жилээс жилд цар хүрээ тэлж буй “НҮҮДЭЛЧИН – ДЭЛХИЙН СОЁЛЫН НААДАМ” нь зүгээр нэг урлаг, спортын баяр биш — Монголын аялал жуулчлалын эдийн засгийн өсөлтийг дэмждэг, орон нутгийн бизнесийг дэмждэг, Монголын өв соёлыг дэлхийд таниулах стратегийн томоохон эвент болон хөгжиж байна. 2026 оноос эхлэн уг наадам олон улсын оролцоогоо өргөжүүлж, Монгол Улсыг дэлхийн нүүдлийн соёлын төв болгон бэхжүүлэх зорилт тавин ажиллаж байна. Энэ нь Монголын аялал жуулчлалын улирлын бус үеийг идэвхжүүлэх, соёлын аяллын бүтээгдэхүүнийг баяжуулах үндсэн чиглэлтэй уялдаж буй юм.



МОНГОЛ УЛСАД 2026 ОНД БОЛОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ НЭГДСЭН ХУАНЛИ
I УЛИРАЛ

1-р сар	2-р сар	3-р сар
Хөнгөн дэлхийн аварга шалгаруулах нэсөн шалгар тэмцээн 13-14 Хангай	Улаанбаатар өвлийн наадам 1 Улаанбаатар	Улаанбаатар өвлийн өргөн алхатан фестиваль 28-31 Улаанбаатар
"Мөөгөлөг шалгуур" шат мөсний наадам 16-18 Ховд	"Аян дуусийн наадам" нэсөн шалгар хараа 1 Сэлэнгэ	"Хөх сүлд" мөсний баяр 2-4 Хөвсгөл
"ААА winter" өвлийн наадам 16-18 Архангай	Түхэн тэнгэрийн баяр 6-8 Өмнөговь	"Эзжийн чамсан шай" зөөнт 4-6 Сэлэнгэ
Охги-Улаан нуурын мөсний баяр 17 Өмнөговь	"Тунгалаг толбо" мөсний баяр 7-8 Баян-Өлгий	Бүргэдийн баяр 7-8 Улаанбаатар
"Елүү Сар-2026" нэсөн сурин чуулга 17-18 Ерөө сум	Бүрэлтийн өвлийн наадам / ICE Digi, Мөсний шалгар, Мөсний сурин хараа, мөсний загасчлан 7-8 Дархан-Уул	Тойгмт жиж 9-15 Улаанбаатар
Мөсөн сурин хараа 17 Баянхонгор	Өвлийн "Алтаргана" наадам 7-8 Дорнод	"Хөвсгөлийн цам" спорт загасчлан тэмцээн 13-16 Хөвсгөл
"Маднар" өвлийн зөөнт 17-19 Хөвсгөл	Их говийн тэмцэ 7-8 Дорноговь	Нүүдэлчдийн баяр 15 Баян-Өлгий
"Түрэмгийн нэгдсэн талст" зөөнт 20 Хангай	Тэнгэрийн баяр 13 Хангай	Түхэн Бүргэдийн баяр 21 Баян-Өлгий
Хар усан голын жавар 23-24 Баянхонгор	Цах, цасны баяр 27-28 Хөвсгөл	Нарны баяр 22 Улаанбаатар
Тэмцэн дээрээс наран ойрхон тэнгэрчдийн баяр 23-25 Дундговь	Улаанбаатар өвлийн өргөн алхатан фестиваль 28-31 Улаанбаатар	Раданы цам спорт загасчлан тэмцээн 27-30 Хөвсгөл
"Дархан цам" өвлийн мөсний загасчлан 28-29 Дархан-Уул		
Өгий нуурын өвлийн наадам 30-31 Архангай		
Улаанбаатар өвлийн наадам 31 Улаанбаатар		

MICE Соёл, амралт, жуулчлал Спорт

МОНГОЛ УЛСАД 2026 ОНД БОЛОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ НЭГДСЭН ХУАНЛИ
III УЛИРАЛ

7-р сар	8-р сар	9-р сар
"АРА" фестиваль 1-31 Архангай	Тал нутгийн соёл 1-2 Дорнод	"Сөөгт Салт" Олон улсын амьдралын 18-17 Өмнөговь
Харлэгийн баруа 1-2 Дундговь	"Ойрад Улсын Зүүн-2026" ОУ-ын наадам 4 Увс	СОГО / НГБ-ын дэлхийн тусгай өмнөговь тусгай Ир бага хурал 17-28 Улаанбаатар
"Гүлтайн" хөгжмийн наадам 2-4 Улаанбаатар	Орхон мөсний байрны 99 байрны шалгар 5 Архангай	Golden Sand-2026 18-20 Увс
"Цаатан" фестиваль 6-7 Хөвсгөл	"Uli food" фестиваль 6-9 Улаанбаатар	"Улаан дэнбү түрэмгийн наадам" 20-23 Дундговь
"Дэлхий Монгол" наадам 9 Улаанбаатар	Орхон мөсний дүүргийн баяр 7 Архангай	"Увс хөр шалгар" цэвэр дүүрэг баяр 21 Дундговь
"Төвийн наран" наадам 10 Дундговь	"Айраг Фестиваль 2026" 7-8 Булган	Денсээр фестиваль 21-23 Өмнөговь
Үндэсний их баяр наадам 10-13 Улаанбаатар	Айрагны баяр 8 Архангай	Олон улсын Монголч хөгжмийн 100 их урал 21-24 Улаанбаатар
Хануул Фестиваль 15-20 Завхан	Хуучин хэдэн 8 Дорнод	"Нүүдэлчдийн дэлхийн соёл фестиваль" 22-24 Улаанбаатар
Этнос фестиваль-2026 15-18 Увс	"Эрхгүй мөсний халуус" зөөнт 8 Хангай	Монголын мэргэжлийн явца 25 Улаанбаатар
"Хоймор" фестиваль 16-18 Сэлэнгэ	"Морел хараа" ОУ-ын улсын шалгар харааны наадам 8 Баянхонгор	Улаанбаатар олон улсын өргөн алхатан фестиваль 28-30 Улаанбаатар
"Нүүдэлчдийн орчингүй" үндэсний урлагийн тоглолт 15-25 Өвөрхангай	"Өргөн Сэлэнгэ" амьд хөгжмийн наадам 8 Сэлэнгэ	Mining Week 2026 Уул уурхайн дотоо хоног / чуулга хурал, олоогийн 28-30 Улаанбаатар
"Арагтар хэрэг" адууны наадам 18-19 Өвөрхангай	"Торгоны зам-Хархорум хот" фестиваль 8-9 Өвөрхангай	Үндэсний спортын VII наадам 28-30 Улаанбаатар
"Монгол эхний урлагийн баяр" 22 Өвөрхангай	"Хөр нарын хөдөөд" олон улсын марафон 8-15 Хөвсгөл	БНХАУ-ын Зүүн хойд хөдөө нүүдлийн байрны уралт 28-30 Улаанбаатар
Сарлагийн баяр 23 Өвөрхангай	Тарвааны баяр 14-16 Ховд	"Төгрөгний бумба төмөр" 28-30 Сэлэнгэ
Алуунго эхний сургаалийн баяр 29-30 Хөвсгөл	"Алтан эс" элсэн мөсний баяр 14-16 Өмнөговь	БНСУ-ын КОТВА-тай хатгалсан элсэлтийн хөгжмийн арга 28-30 Улаанбаатар
"Хадан зам" Бурхан Хандунас Хархорум хурал түүхэн амьдрал жуулчлалын зөөнт 30-05 Улаанбаатар	"Хуучин 2026" өмнөговь аварга шалгаруулах тэмцээн 18 Дархан-Уул	
"OECD Competition Law" ОУ-ын эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын 30-05 Улаанбаатар		

MICE Соёл, амралт, жуулчлал Спорт

МОНГОЛ УЛСАД 2026 ОНД БОЛОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ НЭГДСЭН ХУАНЛИ
II УЛИРАЛ

4-р сар	5-р сар	6-р сар
Hospitality and Tourism International Expo 2026 3-4 Улаанбаатар	Ул бүдгэрэн их өв 1-3 Дорнод	"Улаанбаатар Grand Slam 2026" цэвэр бөхийн тэмцээн 6-7 Улаанбаатар
Norica Mongolia Conference 2026 10 Улаанбаатар	"Үндэсний бичиг, үсгийн баяр" 3 Улсын хэмжээнд	Red fest nomadic motorcycle tour festival 5-6 Дархан-Уул
Дархан тайж Хасарын хөрмөжт Төвийн бүсийн аварга шалгаруулах тэмцээн 11 Дархан-Уул	"Повер эжол" авто уралдаан 8-10 Улаанбаатар	"Хөнгөн мастер кросс" уралдаан 5-6 Дархан-Уул
Оюуны отогийн VII наадам 18 Улаанбаатар	Даль цэцгийн баяр 10 Хөвсгөл	"Талын Сэлэнгэ" өмнө улсын мөс наадам 6-7 Улаанбаатар
	"Үндэсний бичиг соёл, номын адаг" 16-17 Улсын хэмжээнд	Азийн өргөн жуулчлалын форум 11-13 Улаанбаатар
	"Хасарын найраг" гэрэл зурагчдын өдөрлөг 16 Дундговь	"Тэнгэр" бөхийн наадам 12-15 Улаанбаатар
	Төвөөдөгний Азийн АШТ 19-24 Улаанбаатар	Тогорууны баяр 13-14 Хангай
	"Хөнгөнхон шугуйн шалгарын тайрм" 22-25 Булган	Дархан хайрманы тэмцээн 15 Дархан-Уул
	Сайжаны сарлагийн баяр 23 Өмнөговь	Евразийн музейн форум 15-20 Улаанбаатар
	"Улаанбаатар Тройнл Эжол" 29-31 Улаанбаатар	"Улаанбаатар Grand Slam 2026" адаг бөхийн тэмцээн 19-21 Улаанбаатар
	"Дархан Марафон-2026" 30 Дархан-Уул	"Дэлхийн адууны баяр" 10,000 мөсний парад ОУ-ын наадам 20-23 Өвөрхангай
	Бурхан багшийн их дүйчин асар 31 Улаанбаатар	Цайны амьдрал хөрмөжт олон улсын авто ралли 20 Улаанбаатар
	"Архмийн" дүрлэн урлагийн үзэжлэл 30 Улаанбаатар	"Ретт" мөсний наадам 20 Улаанбаатар
	"Шатрын Азийн" АШТ 30 Улаанбаатар	Адууны түрмий соёл 21 Сэлэнгэ

MICE Соёл, амралт, жуулчлал Спорт

МОНГОЛ УЛСАД 2026 ОНД БОЛОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ НЭГДСЭН ХУАНЛИ
IV УЛИРАЛ

10-р сар	11-р сар	12-р сар
"Талын төрөөн" тайга хоног 3-4 Хангай	Norica Mongolia Expo 2026 6-8 Улаанбаатар	Khukhree ice festival 5-8 Өвөрхангай
"Golden Eagle" бүргэдийн баяр 3-4 Баян-Өлгий	"Алтан хурал" Монгол туургатны адуу соёлын их наадам 6-7 Сүхбаатар	Ламын гэгээний улаан тэнгэрийн баяр 15-16 Баянхонгор
Дархан хотын өдөр 15-16 Дархан-Уул	Чингисийн хөрмийн хоног 7-8 Дорнод	"Монгол өдөр" 31 Дархан-Уул
"Дархан дрифт" аварга шалгаруулах тэмцээн 18 Дархан-Уул	Монгол бахархлын өдөр /Монгол наадам/ 21 Хангай	
Аймгийн Засаг даргын хөрмөжт "Тал өд" адуу найргийн 25 дах наадам 22 Дархан-Уул	"Болор цам" адуу найргийн наадам 26 Улаанбаатар	
ITM-Mongolia ОУ-ын өргөн жуулчлалын үзэжлэл 23-25 Улаанбаатар	Иргэний андгай өргөх ёслол 26 Улаанбаатар	
"Морон мөс" олон улсын бөхийн наадам 28 Улаанбаатар	Талын түрэн адуу 21-22 Хангай	
"Цайны замын түү" олон улсын эрдэнэ цэмцэгээний хурал 30 Улаанбаатар	Тэнгэрийн баяр 28-29 Увс	

2026 ОНД БОЛОХ АРГА ХЭМЖЭЭ

"Монгол-Сингапур" нь "Хот байгуулалт, өрн сууцруулалтын хөгжил" хамтын ажиллагааны чуулга	төв азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа /КАРЕК/ нь хөтөлбөрийн ажил жуулчлалын салбарын хурал	төв азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаа /КАРЕК/ нь хөтөлбөрийн сайд нарын хурал
Их түмэн санхүүжилт бус нутгийн хамтын ажиллагааны хөтөлбөрийн Сайд нарын бага хурал	Бүтээгч ба нүүдлийн мал аж ахуй эрхлэгчдийн олон улсын жилийн тэмдэглэл	

MICE Соёл, амралт, жуулчлал Спорт



АЗИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ФОРУМ 2026 Asia Tourism Forum 2026 — Анх удаа Монголд!

2026 оны 6 дугаар сарын 11-13-нд Улаанбаатар хот Азийн аялал жуулчлалын салбарын хамгийн нэр хүндтэй арга хэмжээ болох Азийн Аялал Жуулчлалын Форумыг анх удаа хүлээн авах гэж байна.

Энэ жилийн гол сэдэв: “Зочлох үйлчилгээ, Аялал жуулчлалын Азийн парадигм”
Зохион байгуулагчид:

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам
Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо (МТО – НЭЗХЭ)
Хонгконгийн Политехникийн их сургууль

ATF 2026 яагаад онцгой вэ?

Ази болон дэлхийн 100 гаруй эрдэмтэн, судлаач, бодлого тодорхойлогчид, хөрөнгө оруулагчид Монголд чуулна. Монголын аялал жуулчлалын боломж, соёл, амьд хэв маяг, зочломтгой уламжлалыг дэлхийд таниулах хамгийн том индэр нээгдэж байна. Форум нь судалгаа, бодлого, инновац, маркетинг, дижитал хөгжил, тогтвортой хөгжлийн академик + практик туршлагыг нэг дор төвлөрүүлэх олон улсын платформ юм.

Гол сэдвүүд

- Зочломтгой үйлчилгээ ба Азийн шинэ парадигм
Эртний нүүдэлчин үеэс эхтэй Монголын зочломтгой соёл өнөөдрийн hospitality стандартыг хэрхэн шинэчилж чадах вэ?
- Соёл ба аялал жуулчлал
Уламжлал, ахуй, өв соёл дээр суурилсан аяллын шинэ шийдлүүд.
- Тогтвортой хөгжил ба нөхөн сэргээх аялал жуулчлал
Байгаль, малчин бүсийн амьдралыг хамгаалахын зэрэгцээ аяллыг урт хугацаанд хөгжүүлэх бодит загвар.
- Инноваци ба AI
Зочид буудал, аяллын үйлчилгээний роботууд, хиймэл оюун ухааны нөлөө.
- Тансаг зэрэглэлийн аялал, тусгай сонирхлын аялал
Монголын онгон байгаль дээр суурилсан high-end аяллын шинэ боломж.
- Эрүүл мэндийн болон wellness аялал
Монголын байгалийн нөөцөд тулгуурласан сувилал, амралтын шинэ тренд.

Яагаад оролцох ёстой вэ?

- Олон улсын судлаач, хөрөнгө оруулагчтай шууд уулзах
- Судалгаагаа олон улсад танилцуулах
- Шинэ төсөл, хамтын ажиллагаа эхлүүлэх
- Салбарын бодлого, инновац, сорилт ба шийдлийн шинэ мэдлэг авах



The Asia Tourism Forum (ATF) was founded in 1993 to address important issues facing Asia's tourism industry, particularly in the areas of development, service management, marketing and sustainability. The 15th Asia Tourism Forum 2026 (ATF 2026) is designed with the theme of “The Asian Paradigm in Hospitality and Tourism” for tourism academia and practitioners to share their insights. The forum is co-hosted by School of Hotel and Tourism Management, The Hong Kong Polytechnic University, and Mongolia Tourism Organisation in Ulaanbaatar, Mongolia on 11-13 June 2026.

Join us on a journey through the captivating history of Ulaanbaatar, where ancient nomadic traditions blend seamlessly with modern vitality. Discover a unique tapestry of culture, heritage, and the warm hospitality that defines Mongolia. Share your knowledge and engage in discussions about tourism and hospitality in the Asian Paradigm.

Call for Papers

The Forum invites submissions of research papers on (but not limited to) the following topics:

- | | |
|--|--|
| <ul style="list-style-type: none"> • Hospitality and Tourism in the Asian Paradigm • Asian Hospitality • Culture and tourism • Innovation and Entrepreneurship • Luxury Experiences Management • Sustainable Tourism and Regenerative Tourism • ESG (Environmental, Social, Governance) in Tourism • DEI (Diversity, Equity, Inclusion) in Tourism • Health and Well-being • AI and Service Robotics | <ul style="list-style-type: none"> • Digital Transformation • Tourism Planning and Development • Pedagogies and Innovations in Tourism and Hospitality Education • Nature-based Tourism • Rural Tourism • Urban Tourism • Tourism Economics and Forecasting • Destination Management and Marketing • Other topics relevant to the theme of the conference |
|--|--|

The Forum invites two types of submissions written in the format and style described in the Publication Manual of the American Psychological Association:

- Abstract (maximum 1,000 words including the reference section) or
- Full paper (maximum 5,000 words including the reference section)

The author's name and affiliation should be shown only on the cover page of the manuscript, and they should not be indicated anywhere in the paper. Once the submission is accepted, at least one of the authors must register and present at the conference.

Schedule



Please send your paper submission to Dr Jinah Park, Assistant Professor, School of Hotel & Tourism Management, The Hong Kong Polytechnic University: jinah.park@se.hk
Please visit <https://atf2026.mto.mn/> for more information about the Forum, paper submission and registration.

Бүртгэл ба мэдээлэл:
И-мэйл: training.mto2@gmail.com
Утас: 7712-8822, 8609-9501



www.atf2026.mto.mn



“ТЭНГЭРИЙН ХУТАГТ” ФЕСТИВАЛЬ 2025 ГОВИЙН СОЁЛ, СЭТГЭЛИЙН ЭНЕРГИЙГ НЭЭЖ ӨГСӨН ХОЁР ӨДӨР

Говийн ноён хутагт, их соён гэгээрүүлэгч Данзанравжаа V хутагтын мэлмий гийсний 222 жилийн ой–д зориулсан “Тэнгэрийн Хутагт” фестиваль 2025 оны 9-р сарын 19–20-нд Дорноговь аймагт анх удаа амжилттай зохион байгуулагдлаа. Энэхүү фестиваль нь говийн үзэсгэлэнт тал, хутагтын гэгээн ертөнцийг үндэс болгон соёл, урлаг, гэгээрэл, аялал жуулчлалыг нэгтгэсэн улсын хэмжээнд анхны цогц арга хэмжээ боллоо.

**Хоёр өдөрт: 25,000 үзэгч –
4.2 сая хүнд хүрсэн цахим нөлөөлөл**

Фестивалийг орон нутгийн иргэд, жуулчид нийлсэн 25 мянган хүн үзэж сонирхсон. Цахим орчинд: 4.2 сая хүнд хүрсэн үзэлт, 70% нь эерэг сэтгэгдэл Gobi.mn, Дорноговь аймаг, “Тэнгэрийн хутагт festivaly” цахим хуудас зэрэг сувгуудаар өргөн сурталчлагдсан.

Гурван тайз – Гурван өөр ертөнц
Фестивалийн өвөрмөц онцлог нь гурван өөр орон зайд, гурван өөр энергитэй уран бүтээл, гэгээрлийн хөтөлбөрүүдийг нэгэн зэрэг толилуулсан явдал байв.

**“Тэнгэрийн Хутагт” тайз —
Нүүдлийн театрын дахин төрсөн түүх**
Фестивалийн энэхүү хэсэгт Монголын урлаг соёлын сор болсон уран бүтээлчдийн шоу тоглолт, Дорноговь аймгийн мэргэжлийн урлагийн байгууллагын болон авьяаслаг хүүхдүүдийн нэгдсэн урлагийн тоглолт, Ноён хутагтын музей, 14 сумын соёлын өвийн гэр үзэсгэлэн, “Цагийн жамыг тодруулагч цаасан шувуу” эвэнт, говийн шөнийн “Од дурандах” үйлчилгээ, “Түүдэг тойрсон хууч” оройн хөтөлбөр, өвлөн уламжлагчдын тоглолт, Дорноговь аймгийн брэнд бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа,

гэрэл зургийн үзэсгэлэн зэрэг олон төрлийн үзүүлбэрүүдийг толилууллаа.

“Үлэмжийн Чанар” тайз — Дотоод аяллын орон зай
Шамбалын уур амьсгал бүхий энэ орчинд:
• Иог, хөгжимт бясалгал
• Энергийн засал, арт терапи
• Сэтгэл засал, оюун санааны ярилцлага
Б.Нарандэлгэр, Ч.Ганчимэг зэрэг олон мэргэжилтэн хөтөлбөр удирдан оролцов.

**“Өвгөн Суварга” тайз —
Хамарын хийдийн ариун орон**
IX Ноён Хутагт Данзанлуvsантүдэв айлтгал айлдав. Хамарын хийд, Гандантэгчэнлин хийдийн лам нар хурал ном хуриw. Гавж Д.Нямсамбуугийн “Ёс суртахуун ба бясалгал” лекц “Үлэмжийн чанар” яруу найргийн наадам, нутгийн лимбэчдийн тоглолт боллоо.

**Говийн аялал жуулчлалыг дэмжсэн
шинэ соёлын загвар**
Энэхүү фестиваль нь Дорноговь аймгийн 2025 оны “АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ДЭМЖИХ ЗОРИЛТОТ ЖИЛ”-ийн хамгийн том арга хэмжээ болж, говийн соёлын өвийг шинэ хэлбэрээр олон нийтэд хүргэв. Мөн аялал жуулчлалын улирлын бус үеийг сэргээх шинэ бүтээгдэхүүн бий болгов.

**“Тэнгэрийн Хутагт” фестивалийг Дорноговь аймаг
жил бүр уламжлал болгон зохион байгуулахаар
шийдвэрлэсэн бөгөөд дараагийн фестиваль
2026 оны 9 дүгээр сарын 10–11-ний өдөр зохион
байгуулагдах тов гарчээ.**

2026.09.18-19
Дорноговь аймаг

Тэнгэрийн хутагт Festival



“Тэнгэрийн Хутагт” – Говийн энерги,
Монгол соёлын шинэ брэнд



► Монгол Улсад нисэх хүчин байгуулагдсаны 100 жилийн ойд зориулсан ярилцлага

ИНЕГ-ын дарга Э.Төрбаяр: Нээлттэй өрсөлдөөн бий болсноор тийзийн үнэ дунджаар 40 хүртэл хувиар буурах боломжтой



Шатахуун, татвар, валютаар гарах зардал өндөр байгаа нь үнийн өсөлтийн гол шалтгаан. Шийдлийн хүрээнд шатахууны үнийг тогтворжуулах, орон нутгийн нислэгийг НӨАТ-аас чөлөөлөх зохицуулалт хуулийн төсөлд туссан. Мөн тээвэрлэгчид бага өртөгт бизнес модел нэвтрүүлэх, зардал бууруулах чиглэлээр ажиллаж байна. Шаардлагатай тохиолдолд төрөөс нөхөн олговортой нислэгийн бодлого хэрэгжүүлдэг.

– Улирлын хэлбэлзэл, ялангуяа өвлийн аялал жуулчлалд ямар зохицуулалт хэрэгтэй вэ?

Монголын газарзүйн онцлогоос шалтгаалж тээврийн хүртээмж улирлаас ихээхэн хамаардаг. Улирлын хэлбэлзлийг бууруулахын тулд нээлттэй тэнгэрийн бүс нутгийн хэлэлцээрт нэгдэх, дэд бүтцээ шинэчлэх, нисэхийн хүний нөөцийг хөгжүүлэх, Монголыг бүс нутгийн транзит, логистикийн төв болгох зэрэг дунд, урт хугацааны бодлого чухал.

– Нисэх буудлын төлбөр, тарифын өөрчлөлт аялал жуулчлалын өсөлтийг хэрхэн харгалздаг вэ?

“Монголд зочлох жил”, “Транзит Монгол” зэрэг бодлоготой уялдуулан транзит зорчигчийн хураамжийг бууруулах, зохистой тариф тогтоох ажлыг судалж байна. 2024 оноос эхлэн Чингис хаан ОУНБ-ын хураамжийг эдийн засгийн үндэслэлтэйгээр өөрчлөх боломж нээгдсэн бөгөөд тийзний үнэ тогтвортой байх, транзит урсгал татах, аялал жуулчлалын өсөлтөд эерэг нөлөөтэй байхаар тооцоо судалгаа хийгдэж байна.

Танд баярлалаа. ■

► – Агаарын тээврийн салбарын эдийн засгийн зохицуулалт ямар шинэчлэл хийж байна вэ?

2025 оноос мөрдөж эхлэх Иргэний нисэхийн тухай шинэчилсэн хуулиар эдийн засгийн зохицуулалтын чиг үүрэг салбарын яаманд шилжинэ. Үүний дагуу олон улсын нислэгийн томилгоо, үйлчилгээний төлбөрийн хэмжээ, зорчигч тээвэрлэлтийн нөхцөл, даатгал, статистикийн журам зэрэг эдийн засгийн зохицуулалтын бүх дүрмийг шинэчлэн боловсруулж, батлуулахаар бэлэн болгосон.

– Либералчлал болон үнийн бодлого аялал жуулчлалын үнэ ханшид хэрхэн нөлөөлөх вэ?

Нээлттэй өрсөлдөөн бий болсноор тийзийн үнэ дунджаар 40 хүртэл хувиар буурах боломжтой. Гэхдээ дотоодын тээвэрлэгчид өрсөлдөөнд бэлэн байх ёстой. Тиймээс либералчлалыг үе шаттай хэрэгжүүлж, хямд үнэ, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ үндэсний

авиа компаниудаа хамгаалах бодлого зэрэгцэн явагдаж байна.

– “Нээлттэй тэнгэрийн бодлого” аялал жуулчлалын өсөлтөнд ямар нөлөө үзүүлэв?

2024 онд Монголд ирсэн жуулчдын 85 гаруй хувь нь агаарын тээврээр зорчсон. Олон улсын шууд нислэгийн тоо нэмэгдсэнээр Монгол руу зорчих боломж, хүртээмж сайжирч, манай улс бүс нутгийн аялал жуулчлалын чухал цэг болох нөхцөл бүрдэж байна.

– Шинэ чиглэлүүдийг нээх бодлого хэрхэн хэрэгжиж байна вэ?

Монгол Улс 49 улстай 260 гаруй цэгт нислэг хийх эрх зүйн орчин бүрдүүлсэн. Дотоодын 5 тээвэрлэгч нийт 139 чиглэлд томилгоо авсан. Шинэ чиглэл нээх хүсэлтэд судалгаа, тооцоог шуурхай хийж, хоёр улсын хэлэлцээрийн дагуу томилгоо олгодог.

– Дотоод нислэгийн өндөр үнэ аялал жуулчлалд сорилт болдог. Шийдэл юу байна вэ?

WELCOME TO
THE CORPORATE
HOTELS
★★★★★

Whether you are travelling for business or pleasure, The Corporate hotels offer services under one roof making it an ideal choice for your stay. The hotel's warm surroundings, comfort, modern touches and a high quality service sets it apart from any other hotel, allowing you to feel like being at home from your very first steps into the hotel. The first chain hotels in Mongolia, The Corporate hotels have four branches. Two branches located in a beautiful nature nearby Bogd Mountain provide full opportunities to relax and conduct business meetings in a comfortable environment. The branch located in the central zone of the city has an event hall and a concert hall that can be transformed from a concert hall into a cinema.








(976) 7000 2030 (976) 9911 1355
mail@corporatehotel.mn
www.corporatehotel.mn

МОНГОЛЫН ӨВӨЛ — ДЭЛХИЙД ХОСГУЙ АЯЛЛЫН ТУРШЛАГА

Монгол орны өвөл бол зөвхөн хүйтний улирал биш. Харин байгаль, соёл, уламжлал гурвын гайхамшигийг нэгэн зэрэг мэдрүүлдэг, дэлхийд дахин давтагдашгүй аяллын улирал юм. Жилээс жилд өвлийн аялал жуулчлалын эрэлт өсөж, Монголыг зорих жуулчдын тоо нэмэгдэж буй нь өвлийн аялал манай улсын дараагийн том боломж болсныг харуулж байна.

Өвлийн Монголд ирсэн жуулчдын анхны сэтгэгдэл — “Хамгийн үзэсгэлэнтэй, хамгийн онцгой өвөл Монголд байдаг”. Цасанд дарагдсан тал нутаг, хөх тэнгэрийн гэгээ, хүйтний эрчийг ажрахгүй нүүдэлчдийн амьдрал жуулчдад гайхамшиг мэт санагддаг.

Монголын өвлийн хамгийн сонирхолтой эрэлттэй аяллууд:

- **4x4 адал явдалт цас-мөсийн жимээр зорчих аялал**

Монголын уудам тал, уулс, мөсөн хөндийг туулах өвлийн бартаат замын (off-road) тур аялал нь адал явдал хайгч жуулчдын хамгийн дуртай бүтээгдэхүүн.

- **Халх, Буриад, Дархад, Хотгойд язгуурын соёлтой өвөлжөөний зан үйл**

Монгол угсаатны өвөрмөц ёс заншил, өвлийн ахуй, уламжлалт амьдралын хэв маягийг нэг дор таниулсан өв соёлын хөтөлбөр.

- **Хөвсгөл нуурын Мөсний баяр**

Азийн хамгийн том мөсөн баяруудын нэг — мөсөн урлаг, спортын тэмцээн, мөсөн гулгуур, үндэсний тоглоом, соёлын шоу хосолсон өвлийн гол фестиваль.

- **“Талын Түмэн Адуу” — адуун соёлын олон улсын наадам**

Нүүдэлчдийн адуучин соёл, ухаан, морин спорт, адууны уралдаан, гоёлын наадам бүхий томоохон өв соёлын арга хэмжээ. Монголын адууны соёлыг олон улсын түвшинд сурталчилдаг жил бүр хийгддэг уламжлалт наадам болж өргөжсөөр байна.

- **Цаатан иргэдтэй танилцах тундрын аялал**

Тайга дахь цаа бугын ахуйтай танилцах, нүүдлийн соёл, өвлийн тайгын байгаль орчинтой танилцах онцгой туршлага болдог.

- **Өвлийн монгол наадам: мөсөн шагайн харваа, морин уралдаан**

Монгол ахуй, уламжлалт спортын төрлөөр өвөл зохион байгуулагддаг тусгай хувилбаруудтай баяр. Өвлийн морин уралдаан, мөсөн шагайн харваа, “Өвлийн наадам” хөтөлбөрүүд нь жуулчдын сонирхлыг өндөрөөр татдаг.


- **Хотын өвлийн гэрэлтүүлгийн фестивалиуд**

Улаанбаатар болон аймгийн төвүүдэд зохион байгуулагддаг гэрлийн шоу, мөсөн баримлын үзэсгэлэн, гэрэлт инсталляци бүхий гэрэлтүүлгийн баярууд өвлийн аяллын шинэ трэнд болж байна.

Халуун орны орнуудаас ирсэн аялагчид Монголын өвлийг заавал мэдрэхийг хүсдэг болсон. Тэдний хэлснээр: - **“Маш хүйтэн мөртлөө зүрх дулаацуулсан, байгаль нь тайван мөртлөө хүчтэй, яг л амьд музей мэт улс байна”** хэмээн сэтгэгдлээ хуваалцжээ.

Өвлийн аялал жуулчлал нь зөвхөн туршлага мэдрүүлэх аялал төдийгүй орон нутгийн иргэдийн орлогыг нэмэгдүүлдэг, тогтвортой аялал жуулчлалын хөгжлийн гол тулгуур болсон салбар юм. Малчин өрх, гар урчууд, тээвэр үйлчилгээ, жижиг бизнесүүдийн бүх орлого өвлийн аяллын улиралд мэдэгдэхүйц өсдөг байна.

Монгол орны өвөл — цэвэр ариун байгаль, нүүдэлчдийн соёл, бодит амьдралын туршлага, мөс цасны эрч хүчийг нэгтгэсэн жинхэнэ гайхамшигийн аялал юм. Дэлхийн бусад улс орнуудад давтагдашгүй, Монголын өвлийн аяллыг цаашид брэнд бүтээгдэхүүн болгон хөгжүүлэх бүрэн боломж бидэнд бий.





ТЭРБУМ МОД ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН

2025 ОНЫ 11-Р САРЫН БАЙДЛААРХ ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Монгол Улсын “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн 2021–2030 онд хэрэгжиж буй бөгөөд 2025 оны байдлаар улсын хэмжээнд ойжуулалтын ажил үе шаттайгаар, бодитоор хэрэгжиж байна. Аймаг орон нутгийн оролцоо, уул уурхайн компаниудын дүйцүүлэлтийн ажил төдийгүй аялал жуулчлалын салбар ногоон шилжилтэд нэгдэн “Жуулчин төгөл” байгуулах ажлыг эхлүүлсэн нь онцлох үр дүн болж байна.

ЖУУЛЧИН ТӨГӨЛ – АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАР НОГООН БОДЛОГОД НЭГДЛЭЭ

2025 онд аялал жуулчлалын салбар “Тэрбум мод” хөдөлгөөнд идэвхтэй нэгдэж, жуулчин бүрээс байгальд үлдэх эерэг үл мөрийг бий болгох зорилготой “Жуулчин төгөл” байгуулах ажлыг эхлүүллээ.

- Тур операторууд жуулчдын тоотой уялдуулан нэг жуулчин – нэг мод зарчмаар ногоон төгөл байгуулж эхэлсэн.
- Жуулчны бааз, амралтын газрууд өөрийн брэнд төгөлийг бий болгож, тарьсан модны мэдээллийг цахимаар жуулчинд илгээдэг систем нэвтэрч байна.
- 2025 оны байдлаар аялал жуулчлалын салбарын дэмжсэн мод тарих ажил анхны 50 мянган модоор эхэлсэн бөгөөд 2026 онд энэ тоо 10 дахин өсөх төлөвтэй байна.
- “Жуулчин төгөл” нь салбарын ногоон маркетинг, тогтвортой аялал жуулчлалын үндэс болох шинэ загвар болж байна

ОЙН ХАМГААЛАЛ – 853.1 МЯНГАН МОДЫГ АВРАВ

16 аймагт хөнөөлт шавжтай тэмцэх ажил хийгдэж, 247.3 мянган га талбайд устгал хийснээр 853.1 мянган модыг хамгаалжээ.

ХАРХОРУМ ХОТЫН НОГООН БҮС

Шинэ Хархорум хотын ногоон байгууламжийн хүрээнд 52 байгууллага хамтран 796.8 мянган мод тарьсан байна.

ОНЦЛОХ ТООН ҮЗҮҮЛЭЛТ

- 116.1 сая мод — Улсын хэмжээнд тарьсан
- 23.9 сая мод — Сэлэнгэ аймгийн гүйцэтгэл
- 20.5 сая мод — Оюу толгой компанийн дүйцүүлэлт
- 853.1 мянган мод — Хөнөөлт шавжаас хамгаалсан
- 796.8 мянган мод — Хархорумын ногоон бүс
- 50,000+ мод — Аялал жуулчлалын салбарын эхлүүлсэн “Жуулчин төгөл” (шинэ үзүүлэлт)



НИЙТ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ

- Нийт тарьсан мод: 116.1 сая
- Аймаг, нийслэлийн гүйцэтгэл: 56.2 сая
- Уул уурхайн компаниуд: 43.7 сая
- Нийт дэвсгэрт хэрэгжилт: 8.27%

АЙМАГ, ААН-ҮҮДИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ОНЦЛОХ ҮР ДҮН

Сэлэнгэ аймаг — 23.9 сая мод (Манлайлагч)
Амлалтаа давуулан биелүүлсэн аймаг.

Орхон аймаг — 3.6 сая мод

Эрдэнэт үйлдвэрийн дүйцүүлэлт өндөр үр дүнтэй.

Хөвсгөл, Дорнод, Булган аймгууд

Хамгаалалтын зурвас, нөхөн сэргээлтийн ажлаараа тэргүүлэв.

Тэргүүлэх ААН-үүд

- Эрдэнэт үйлдвэр — 3.59 сая мод
- Оюу толгой ХХК — 20.5 сая мод дүйцүүлэлт
- Эрдэнэс Тавантолгой ХК — 14.6 сая мод



7775 2002



info@billiontree.mn



www.billiontree.mn



АЛТАН ЦАГИРАГ — ХЭНТИЙН СОЁЛ, БАЙГАЛЬ, ТҮҮХЭЭР АЯЛСАН ШИНЭ МАРШРУТ

Хэнтийн зүрхэнд шинээр нээгдэж буй “Алтан цагираг” маршрут нь нутгийн байгалийн үзэсгэлэн, түүхэн дурсгал, орон нутгийн амьдралыг нэг дор шингээсэн цогц аялал билээ. Говь хээрийн өргөн тал, элсэн манхан, хийдийн ариун орчин, малчны өвөрмөц соёл — бүгд нэгэн аяллын турш мэдрэгдэх тул энэ маршрут нь гэрэл зурагчид, соёл судлаачид, адал явдал эрэлхийлэгчдэд зориулагдсан.

Гол онцлог

- Гурван өнгө аяс: байгалийн тэнцвэртэй ландшафт, нутгийн урлаг, шашин ёслол.
- Орон нутгийн оролцоо: малчин айл, гар урчуудын сурталчилгаа, мастер-класс.
- Тогтвортой туризм: байгаль хамгааллыг эрхэмлэсэн хөтөлбөр, “хоггүй аялал” зарчим.

Жишээ хөтөлбөр

- 1 өдөр: Гол дурсгалт газруудыг үзэж, нутгийн хоол амтална.
- 2 өдөр: Хийд, музей, гэрэл зургийн цэгүүд, орон нутгийн айлд хонох.
- 3 өдөр: Урлагийн мастер-класс, байгаль судлалын богино сургалт, аялал.

Инфраструктур, аюулгүй байдал Маршрут авто болон 4x4-өөр хөндлөн зорчих боломжтой. Зогсоол, гэр буудал, кемпийн талбай, түр эмнэлэг, хөтөчтэй хамтарсан аюулгүй ажиллагааг нэн тэргүүнд хангах шаардлагатай.



Эдийн засаг, нийгэмд үзүүлэх үр нөлөө Алтан цагираг нь орон нутгийн жижиг бизнес, гар урлал, зочид буудлын сүлжээнд тогтвортой орлого оруулах, залуучуудад ажлын байр бий болгох ач холбогдолтой.

Сорилт ба шийдэл

- Зам, логистик сайжруулах, жилийн 4 улиралд тогтвортой ажиллах байршуулах хэрэгслийн тоог нэмэгдүүлэх, тав тух, аюулгүй байдлыг бэхжүүлэх.
- Маркетингийн нэгдсэн стратеги боловсруулж, гадаад жуулчдыг татах.
- Орон нутгийн сургалт, оролцоог нэмэгдүүлхээр ажиллаж байна.

“Алтан цагираг” нь Хэнтийн бодит өнгө төрх, түүх, соёлыг илэрхийлэх боломжтой маршрут ба зөв төлөвлөлт, оролцогч талуудын идэвхтэй хамтын ажиллагаагаар говийн бүсийн аялал жуулчлалын шинэ брэнд болж болох юм.



“ЦАЙНЫ ЗАМ” БРЭНД АВТО АЯЛЛЫГ НЭЭЛЭЭ

Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Оросын Холбооны Улсын аялал жуулчлалын сайд нарын есдүгээр хуралдааны хүрээнд гурван улсын хил орчмын “Цайны зам” брэнд авто аяллын нээлтийн үйл ажиллагаа 2025 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр Дархан-Уул аймгийн Дархан хотноо боллоо.

Энэхүү хуралдаан нь бүс нутгийн аялал жуулчлалын урсгалыг тогтворжуулах, эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, соёлын харилцааг өргөжүүлэх ач холбогдол бүхий гурван улсын хамтын ажиллагааны шинэ шатанд хүргэсэн үйл явдал болсон юм. Аяллын маршрутыг аялал жуулчлал, соёл, эдийн засгийн хамтын ажиллагааны шинэ гүүр болгон сэргээх зорилгоор гурван улсын төлөөлөл хэлэлцэж, “Цайны зам” нэрийн авто аяллын маршрутыг хамтран нээв.



Нээлтийн үеэр Монгол Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд Ч.Ундрам гурван улсын аялагчдын төлөөлөлд “Цайны зам”-ын дурсгалын цом гардуулж, цаашид авто аяллын маршрутыг нэгдсэн стандарттай аяллын бүтээгдэхүүн болгон хөгжүүлэх, гурван улсын аяллын тур операторуудын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд идэвхтэй оролцохоо илэрхийлэв.

“Цайны зам”-ын авто аяллын оролцогчид БНХАУ-аас 2100 км замыг туулан Дархан-Уул аймагт ирээд байгаа бөгөөд Сэлэнгэ аймгийн чиглэлд аяллаа үргэлжлүүлэн, Алтанбулагийн боомтоор дамжин ОХУ руу нэвтрэх юм.



DINO FEST MONGOLIA 2026



Монголын Говийн уудам орон зай, өвөрмөц геологийн тогтоц, элсэн манханы хөдөлгөөнт дүр зураг нь сая сая жилийн тэртээ амьдарч байсан амьд биетүүдийн үлдээсэн түүхийг нам гүмхэн өгүүлдэг, дэлхийн палеонтологийн үнэт сан хөмрөг юм.

Dino Fest Mongolia арга хэмжээ нь говийн бүс нутгаас илэрсэн үлэг гүрвэлийн олдвор, эртний амьд биетийн мөр, геологийн өвийг олон нийтэд шинжлэх ухаанч, сонирхолтой хэлбэрээр хүргэх боломжийг олгоно.

Энэ үнэт өвийг олон нийтэд илүү хүртээмжтэй хүргэх зорилготой “Dino Fest Mongolia 2026” арга хэмжээ нь 2026 оны 8-р сарын 21-23-нд Монголын Говийн үзэсгэлэнт байгальд зохион байгуулагдах гэж байна.



Арга хэмжээний онцлох агуулга:

Dino Fest Mongolia нь үлэг гүрвэлийн судалгаа болон Монголын Говийн палеонтологийн үнэт олдвор, байгалийн өвийг олон нийтэд таниулахын зэрэгцээ аялал жуулчлалыг хөгжүүлэх, байгалийн өвийг хамгаалах ач холбогдлыг уриалах зорилготой. Энэхүү өдөрлөгийн үеэр:

- Хүүхэд багачуудад зориулсан бүтээлч соёлын арга хэмжээнүүд
- Палеонтологийн малтлагын туршлага: **Fossil Dig Experience**
- Геологийн талбайн аялал: **Field Geology Tour**
- VR/AR динозаврын туршлага бүхий **Virtual Dino World**
- Шөнийн “**Fossil Night**” гэрлийн шоу ба одон орон судлалын хөтөлбөр
- **Dino Market & Food Zone** – говийн хоол, үндэсний брэнд, дурсгалын бүс
- Динозавртай холбогдсон интерактив тоглоом, хөтөлбөрүүд
- Монголын болон дэлхийн нэрт археологич, палеонтологичдын оролцоотой мэргэжлийн уулзалт, ярилцлага
- Хүүхдийн **Dino Camp** — бүтээлч сургалт, лаборатори, урлагийн хөтөлбөр
- Монголын говийн үлэг гүрвэлийн өвийг харуулсан гэрэл зургийн болон мэдээллийн үзэсгэлэн
- Археологийн болон палеонтологийн шинжлэх ухааны сургалт, хэлэлцүүлэг
- **Музейн тусгай хөтөлбөр**, танилцуулга хийгдэх юм.

Огноо: 2026. 08. 21-23

Холбоо барих:

Вэб: www.joinmemongolia.com

И-мэйл: info@joinme.mn

Утас: 99098903

DID YOU KNOW THESE FACT ABOUT MONGOLIA?

Population: 3.348 million
Livestock: 71.120 million
Land: 1,564,116 square kilometres

North: Lake Khuvsgul

The impressive Lake Khövsgöl, the largest freshwater lake in Mongolia and one of the world's 17 oldest lakes, is located on the Russian border. It is a sort of pilgrimage place that is more than 2 million years old and is well-known for leisurely and picturesque multi-day horseback rides across the nearby valleys, marches, and steps.

Mongolia is the 19th largest country in the world

Mongolia is the 2nd largest landlocked country in the world. As of the end of 2022, Mongolia has 4'821'008 horses which is more than the people. Mongols always welcome travelers into their home. Mongolia is famous for hospitality. The only true wild horse is from Mongolia, it's called takhi in Mongolian. The Mongol Empire: Great Mongol was the largest empire in the world. Naadam Festival: the Olympic Games of Mongolia.

LANDSCAPES OF MONGOLIA

Mongolia, the world's least populous nation and a less-traveled region of Asia, is distinguished by its untainted, widely landscapes and some of the world's last nomadic cultures.

Here are five breathtaking landscapes you must see:

West: Altai Mountains

The Altai, Mongolia's largest and highest mountain range, is calling to intrepid hikers and mountaineers. There are numerous multi-day treks across this pristine region that can be accessed from Altai Tavan Bogd National Park, where you can ascend to altitudes of more than 3,000 meters.

Central: The Orkhon Valley

Go to the Orkhon Valley for expanses of lush green forest and rolling hills. Here, many people embark on the short climb to the Tuvkhon Monastery, which is located at an elevation of 2,600 meters, or wander among the ruins of 8th century Turkic monuments.

Southern: Gobi Desert

A remarkable variety of topographies are hidden in the Gobi Desert. Highlights of the Gobi include the Khongoryn Els sand dunes, which are typically accessible by camel from a remote Ger camp, as well as the Yolín Am canyon and ice glacier, as well as the Baga Gazryn Chuluu granite rock formations.

East: The Biosphere National Parks

You must visit Khustain Nuruu National Park to try your luck at spotting a wild Takhi horse, also known as Przewalski's horse. Because of its extraordinary biosphere, which is home to hundreds of rare and unusual species of flora and fauna, it is a protected area. The Takhi was brought back to its original habitat exactly here after going extinct in the wild



Build Tours Faster Sync Everywhere Instantly

Our itinerary builder empowers travel agencies and tour operators to design custom travel experiences effortlessly

Advantages of a Web Builder System

- Responsive Design
- Customer Support
- Integration Capabilities
- Cost-Effective
- Customization
- SEO-Friendly
- Security

Advantages of Our Itinerary Builder System

- Instant Publishing
- Downloadable PDF
- Customization
- Work Efficiency



erxes

Digital Transformation Partner
in The Travel Industry
www.erxes.io

Connect with our travel tech
experts to elevate your business!
info@erxes.io

Take Control of Your Hotel & Resort Operations


Transform your hotel, camp, and resort with our professional website and property management solutions

Property Management System (PMS)

- Efficient Booking Management
- Maintenance Scheduling
- Comprehensive Analytics
- Automated Operations

Professional Website

- Custom Design
- User-Friendly Interface
- Responsive Design



ALL-IN-MONGOLIA
AI-POWERED CONCIERGE ASSISTANCE

Search, discover, and enjoy
everything in Mongolia
www.allinmongolia.com




ӨВ СОЁЛ БОЛ ГОЁЛ БУС МӨН ЧАНАР



"Өв соёл бол гоёл бус — Мөн чанар"

PHOTOGRAPHER - ART.BOSH
MODEL - KUGYEELY



SPIRITUAL TOURISM

Temple stay
Cultural Exchange

Wellness and Mindfulness
Connection to Nature



ТУЗ-ИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ

Хүннү Эйр компани нь 2011 онд байгуулагдсан цагаасаа хойш хүрсэн амжилт, хөгжлөөрөө бид үргэлж бахархдаг. Монгол Улсын дотоодын агаарын тээврийг холбох зорилготой зоримог санаачлагаас эхэлсэн бидний үйл ажиллагаа өдгөө Ази болон Европын 60 гаруй хотыг Монгол Улстай холбосон үндэсний хэмжээний агаарын тээврийн компани болон өргөжин хөгжөөд байна. Өнөөдөр Хүннү Эйр нь Монгол Улсын хоёр дахь том агаарын тээврийн компани болж, энэ амжилт нь манай хамт олны хичээл зүтгэл, түншүүдийн итгэлцэл, мөн Монгол Улсын олон улсын тавцанд өсөн нэмэгдэж буй байр суурийн тод илэрхийлэл юм.

Анхнаасаа бидний алсын хараа тодорхой байсаар ирсэн. Бид зөвхөн тээврийн үйлчилгээ үзүүлэгч байхаас илүүг зорьдог. Бид бол гүүр — орон нутгийг нийслэлтэй, Монгол Улсыг дэлхийтэй, боломжийг хөгжил дэвшилтэй холбох гүүр юм. Бид Монголын агаарын тээврийн салбарт анх удаа Парис хот руу урт зайн нислэг үйлдсэн бөгөөд цаашид шинэ зах зээлийг нээх, агаарын хөлгийн паркаа шинэчлэх, зорчигчдод шударга, аюулгүй, найдвартай үйлчилгээ үзүүлэхийн төлөө тасралтгүй ажиллах болно.

МАК Группийн стратегийн охин компанийн хувьд Хүннү Эйр нь Группийн дэмжлэг, бат бөх сууринд тулгуурлан өөрийн эрхэм зорилгод үнэнчээр урагшилж байна. Энэхүү суурь нь бидэнд амбицтайгаар өсөж хөгжих, сорилт бэрхшээлийг даван туулах, Монгол Улсад бахархалтайгаар, хариуцлагатайгаар үйлчлэх боломжийг олгож байна.

Цаашдын хөгжлийн чиглэл маань инноваци болон хариуцлагад суурилж байна. Бид үйлдвэрээс шинээр нийлүүлэгдсэн Embraer 195-E2 агаарын хөлгийг амжилттай хүлээн авч, ашиглалтад оруулснаар түлшний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй нисэхийн шинэ үеийг эхлүүллээ. Мөн 2025 оны эцэс гэхэд дахин нэг шинэ агаарын хөлгийг флотдоо хүлээн авснаар манай агаарын хөлгийн паркын шинэчлэл, тогтвортой хөгжлийн бодлого илүү бэхжсэн юм.

Цаашид бид Төв Ази, Зүүн Өмнөд Ази болон БНХАУ-ын зах зээлд чиглэсэн нислэгийн сүлжээгээ шат дараатайгаар өргөжүүлэх, дэвшилтэт дижитал шийдлүүдэд хөрөнгө оруулах, мөн олон улсын ESG зарчимтай үйл ажиллагаагаа илүү нягт уялдуулах чиглэлд тууштай ажиллах болно.

Манай зорчигчид, ажилтнууд, түншүүд болон бүх оролцогч талууддаа энэхүү аяллын нэг хэсэг байж ирсэнд гүн талархал илэрхийлье. Бид хамтдаа Монголын тэнгэрийг улам өндөрт өргөж, Азийн зүрхнээс бүс нутгийн агаарын тээврийн ирээдүйг шинэчлэн тодорхойлох болно.

Хүндэтгэсэн,
Бямбаагийн Нямтайшир
Хүннү Эйр ХХК-ийн ТУЗ-ийн дарга



HUNNU AIR

Wings of Mongolia

CHAIRMAN'S GREETINGS

At Hunnu Air, we take great pride in how far we have come since our establishment in 2011. What began as a bold ambition to connect Mongolia domestically has grown into a national airline that now links our country to more than 60 cities across Asia and Europe. Today, Hunnu Air stands as Mongolia's second-largest airline — a testament to our team's dedication, our partners' trust, and the nation's rising presence on the international stage.

From the outset, our vision has been clear: to be more than a transport provider. We are a bridge — connecting provinces to the capital, Mongolia to the world, and opportunity to progress. We were the first Mongolian airline to operate a long-haul route to Paris, and we remain committed to pioneering new markets, advancing our fleet, and serving travelers with integrity, safety, and care.

As a strategic subsidiary of MAK Group, Hunnu Air moves forward with confidence, drawing strength from the Group's support while staying true to its mission. This foundation allows us to grow ambitiously, remain resilient in the face of challenges, and continue serving Mongolia with pride and responsibility.

Our future direction is grounded in innovation and responsibility. With the successful delivery and entry into service of our brand-new Embraer 195-E2 aircraft, we have begun a new chapter of fuel-efficient and environmentally responsible aviation. In addition, the arrival of another new aircraft into our fleet by the end of 2025 has further strengthened our fleet modernization and reinforced our commitment to sustainable growth.

Looking ahead, we will continue to expand our route network across Central Asia, Southeast Asia, and the China region, invest in advanced digital solutions, and align our operations more closely with global ESG principles.

To our passengers, staff, partners, and stakeholders — thank you for being part of this journey. Together, we will continue to elevate Mongolia's skies and redefine regional aviation from the heart of Asia.

Best regards,
Nyamtaishir Byambaa
Chairman of Hunnu Air





HUNNU AIR ОЛОН УЛСЫН SINGAPORE AIRSHOW 2026, WINGS INDIA 2026-Д ОРОЛЦЛОО



- Hunnu Air олон улсын агаарын тээврийн тайзнаа Монгол Улсыг төлөөлөв

Hunnu Air компани 2026 онд Монгол Улсаас анх удаа Азийн агаарын тээврийн салбарын хоёр томоохон арга хэмжээ болох Singapore Airshow 2026 болон Wings India 2026-д амжилттай оролцож, бүс нутгийн болон олон улсын хамтын ажиллагаагаа өргөжүүлэх чухал алхам хийлээ.

Singapore Airshow 2026

2026 оны 2-р сарын 3–8-ны өдрүүдэд Сингапурын Changi Exhibition Centre-т зохион байгуулагдсан Singapore Airshow нь дэлхийн агаарын тээврийн салбарын тэргүүлэгч үйлдвэрлэгчид, операторууд, хөрөнгө оруулагчид болон бодлого тодорхойлогчдыг нэгтгэсэн нэр хүндтэй арга хэмжээ юм.

Тус шоуны үеэр Hunnu Air компани салбарын гол оролцогчидтой уулзалт, хэлэлцүүлэг хийж, бүс нутгийн нислэгийн зах зээл, шинэ үеийн онгоц, тогтвортой хөгжлийн чиг хандлагын талаар санал солилцлоо.

Wings India 2026

Мөн Hunnu Air компани 2026 оны 1-р сарын 28–31-нд БНЭУ-ын Хайдарабад хотод зохион байгуулагдсан Wings India 2026 арга хэмжээнд оролцож, Энэтхэг болон Өмнөд Азийн зах зээл дэх боломжуудыг судалж, хамтын ажиллагааны хүрээгээ тэллээ.

Тус арга хэмжээ нь Азийн иргэний агаарын тээврийн салбарын стратегийн хэлэлцүүлэг, үзэсгэлэн, агаарын үзүүлбэрийг нэгтгэсэн томоохон платформ юм.

Embraer E195-E2 – Hunnu Air-ийн шинэ үеийн флот

Эдгээр олон улсын арга хэмжээний үеэр Hunnu Air компанийн үйлчилгээнд шинээр нэвтрүүлсэн Embraer E195-E2 тийрэлтэт онгоц салбарын мэргэжилтнүүдийн анхаарлыг татлаа.

Hunnu Air нь уг онгоцыг ашиглаж буй Монголын анхны агаарын тээврийн компани болж, бүс нутгийн нислэгийн хүчин чадлаа шинэ шатанд гаргаж байна.

E195-E2 онгоц нь:

- түлшний зарцуулалт багатай
 - дуу чимээ болон нүүрстөрөгчийн ялгарал бага
 - дунд суудалгүй зохион байгуулалттай
- гэдгээрээ зорчигчдын тав тух, байгальд ээлтэй байдлыг хослуулсан шинэ үеийн дэвшилтэт онгоц юм. Олон улсын зах зээл дэх байр сууриа бэхжүүлж байна.

Singapore Airshow 2026 болон Wings India 2026-д оролцсон нь Hunnu Air компанийн олон улсад өрсөлдөх чадвар, брэндийн нэр хүндийг нэмэгдүүлж, бүс нутгийн нислэгийн сүлжээг өргөжүүлэх стратегийн зорилтыг дэмжсэн чухал үйл явдал боллоо.





HUNNU AIR REPRESENTS MONGOLIA AT SINGAPORE AIRSHOW 2026 AND WINGS INDIA 2026 FOR THE FIRST TIME



By participating in two of Asia's most prominent international aviation events, Hunnu Air has taken a significant strategic step toward strengthening its regional and global engagement.

Hunnu Air has successfully participated, for the first time, in Singapore Airshow 2026 and Wings India 2026, representing Mongolia at two of Asia's leading aviation exhibitions. The participation marks an important milestone for the airline in expanding its international presence and strengthening cooperation within the global aviation industry.

Singapore Airshow 2026

Held from 3–8 February 2026 at the Changi Exhibition Centre, Singapore Airshow is one of the world's most prestigious aviation events, bringing together global aircraft manufacturers, airlines, investors, policymakers, and industry leaders.

During the event, Hunnu Air engaged in high-level meetings and discussions focused on regional air connectivity, next-generation aircraft, and sustainable aviation development.

Wings India 2026

Hunnu Air also participated in Wings India 2026, held from 28–31 January 2026 in Hyderabad, India, a major platform for civil aviation in Asia. The event provided valuable opportunities to explore partnerships and growth prospects within the Indian and South Asian aviation markets.

Introducing the Next-Generation Embraer E195-E2

At both international airshows, Hunnu Air showcased its newly introduced Embraer E195-E2 aircraft, which attracted strong interest from aviation professionals and industry stakeholders.

With the introduction of the E195-E2, Hunnu Air became the first airline in Mongolia to operate an E-Jet aircraft, reinforcing its commitment to modernizing its fleet and enhancing regional connectivity.

The E195-E2 features:

- improved fuel efficiency
 - reduced noise and carbon emissions
 - a comfortable cabin layout with no middle seats
- making it a next-generation narrow-body jet that combines passenger comfort with environmental responsibility.

Strengthening Hunnu Air's International Presence

Hunnu Air's participation in Singapore Airshow 2026 and Wings India 2026 has significantly enhanced the airline's international visibility and brand recognition, supporting its long-term strategy to expand route networks and strengthen partnerships across the Asia-Pacific region.





ВІРV: 7-Р ҮЕИЙН НАРНЫ ЭРЧИМ ХҮЧНИЙ ТЕХНОЛОГИ



МОНГОЛ ДАХЬ АЛБАН ЁСНЫ
ОНЦГОЙ ЭРХ БҮХИЙ ТӨЛӨӨЛӨГЧ

**Барилгад суурилуулсан фотоволтайк (ВІРV) Нарны VII үеийн технологи
танилцуулж байна. ВІРV-ээр цэвэр эрчим хүч бүхий ирээдүйг бүтээж,
байгаль орчин, эдийн засагт үзүүлэх нөлөөллийг онцлов.**



**МОНГОЛ ДАХЬ АЛБАН ЁСНЫ
ОНЦГОЙ ЭРХ БҮХИЙ ТӨЛӨӨЛӨГЧ**



ВІРV – Нарны сэргээгдэх эрчим хүчний VII үеийн технологи нь:

1. Эрчим хүч - Ногоон эрчим хүч үйлдвэрлэнэ
2. Ногоон санхүүжилтийн шаардлагыг хангасан стандартуудтай – (Ногоон барилгын гэрчилгээ A+)
3. Уламжлалт фасад, цонх, дээврийг орлох ногоон барилгын материал
4. Галын аюулгүй байдал А зэрэглэл – Нарны панел нь С зэрэглэлтэй байдаг
5. Архитектурын дизайн өргөн шийдэл – 300 нэр төрлийн загвараас сонгох боломжтой
6. Байгальд ээлтэй – Нарны хэт ягаан туяаны хамгаалалттай UV
7. Дулаалгын материал – дулаан +45, хүйтэн -85 хэмийг нэвтрүүлэхгүй, дуу тусгаарлалт, эрчим хүчний хэмнэлттэй шийдэл
8. Өвөл дулааны зардал, зундаа хөргөлтийн /AC/ зардал хэмнэнэ.
9. Хэт ягаан туяаны хамгаалалт – Тасалгааны цэцэгт усалгаа бага орно, тавилгыг гандалтаас хамгаалж, элэгдэл бууруулна
10. Газрын нөөцийн хамгаална
11. Байгалийн нөөц хамгаална
12. Хог хаягдалгүй шийдэл
13. Тогтвортой хөгжлийн 17-оос 8 зорилтод нийцсэн
14. ESG - БОНЗ стандартыг өндөр хангана
15. Наргүй бүрхэг өдөр ч эрчим хүч үйлдвэрлэнэ
16. Ногоон барилгын хамгийн өндөр стандартууд хангасан ISO 23237-2023, GB/T 37655-2019, DB51/T199-2022
17. Илүүдэл сэргээгдэх эрчим хүчний борлуулалтын орлого шинэ эх үүсвэр бий болно
18. Ногоон барилгын гэрчилгээний буцаан олголт өндөр – LEED certificate BIPV>40%
19. Carbon credit-с илүү carbon market өрсөлдөх чадвар
20. Богино холболтын гүйдэл баталгаат тогтвортой 2.30A
21. Барилгын материалаас 2-3 дахин үнэтэй хэдий ч 100-150 жилийн хэрэглээтэй
22. Өртөг нөхөх хугацаа – 10-15 жил
23. Нарны гэрлийн энергийг эрчим хүч болгох ашигт үйлийн коэффициент 33%
24. Үйлдвэрийн баталгаа 25 жил
25. Уламжлалт нарны панелын татаас зогссон, үйлдвэрлэл буурна
26. ВІРV –ыг БНХАУ XV-5 жилийн төлөвлөгөөнд үйлдвэрлэгч, хэрэглэгч, санхүүжүүлэгчид дэмжлэг татаасуудыг шийдэж өгсөн
27. Дулааны бие даасан шийдэл 40% -аас дээш бол Барилга барих зөвшөөрөл - А даалгавар батлах шийдвэрийг Хотын удирдлагаас гаргасан тул төслийн төлөвлөлтийг дулаан, цахилгааны шийдлийг ногоон GB/T 37655-2019 стандартаар төлөвлөснөөр төслийн техникийн нөхцөл авах ажилд олон талын ач холбогдлолтой байна.

БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ,
ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ


БАГА ЗАРДАЛ
ӨНДӨР ҮР АШИГ

ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН
ҮНЭ ЦЭН НЭМЭГДЭНЭ

НОГООН
ЗЭЭЛ

7227 0002, 95 100 220
www.bipv.mn

BIPV MONGOLIA - BIB




Танд сонирхуулахад,

МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Даян дэлхийн 120 орныг жагсаагаад үзтэл манай улсын далбаа нэр 116 дугаарт жагсаж байна.

- Бидний ард байгаа 4 улс: Мозамбик, Танзани, Йемен, Ардчилсан Конго.

Тэд олон саяулаа, бид 3.6 сая хүн амтай. Тэд дайн дажинтай, эдийн засаг нь унасан үзүүлэлттэй байна.



НАРНЫ СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧ VII ҮЕ ТЕХНОЛОГИ БОЛОХ BIPV Монголд нэвтэрлээ

Сүүлийн жилүүдэд дэлхий даяар барилга нь зөвхөн эрчим хүч хэрэглэгч биш, харин эрчим хүч үйлдвэрлэгч болох чиг хандлага хүчтэй хөгжиж байна. BIPV (Building-Integrated Photovoltaics) технологи нь барилгын дээвэр, фасад, шилэн хэсэг зэрэгт нарны эрчим хүч үйлдвэрлэх фотоцахилгаан модулийг нэгтгэж, барилгын гадна фасад, цонхыг хүртэл үр ашигтайгаар төлөвлөж болдог.

Монгол Улсын хувьд жилийн 300 гаруй өдөр нарлаг байдаг тул BIPV технологи нь орчин үеийн ухаалаг барилгуудыг дэмжих, төвийн эрчим хүчний хамаарлыг бууруулах, CO₂ ялгарлыг багасгах хамгийн тохиромжтой шийдэл болж байна. Өнөөдрийн байдлаар БНХАУ-д 4000 орчим шинэ барилга, 4 улирлын хүлэмж, амралт чөлөөт цагаа өнгөрүүлэх төвүүд, оффисын төсөлд BIPV технологийг ашиглагдаж үйл ажилагааны зардлаа бууруулж бизнесийн өндөр ашиг олсоор байна. Учир нь барилгын эрчим хүчний үйлдвэрлэл нь эрчим хүчний хэрэглээнээсээ өндөр төслүүд бол илүүдэл эрчим хүчээ төвийн шугамд нийлүүлж нэмэлт орлогын эх үүсвэртэй болж байна.

Энэхүү технологи нь Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан, цахилгааны ачааллыг бууруулах, орчны бохирдлыг багасгах, цаашлаад “ногоон барилга” болон “Net-Zero Building” концепцын хэрэгжилтэд бодит хувь нэмэр оруулж байна. Ирээдүйд BIPV технологийг өргөн хүрээнд нэвтрүүлснээр Монголын барилгын салбарын тогтвортой хөгжлийг дэмжих боломжтой юм.

БНХАУ-ын газар нутагт одоогоор BIPV технологиор хийсэн барилга байгууламжийн тоо 4000 орчим хүрээд байгаагаас жишээ татаж 4 загварыг танилцуулахаар бэлдлээ.



Ухань хотын Шинжлэх ухаан технологийн төв BIPV технологиор бүтээв



1

Жишиг төсөл 1:

БНХАУ-ын Чэнду хотын Шуанлиу олон улсын нисэх онгоцны буудлын цахилгаан үүсгүүрийн BIPV шилэн фасадаар хийсэн нь:

Байршил: Чэнду, Сычуань муж
Сууриилсан хүчин чадал: 26кВт

Төсөл нь барилгын дээвэрт Кадмийн теллурид фотоволтайк шил болн өнгөт шилийг хослуулан ашиглаж, жилд ойролцоогоор 39,700 киловатт.цаг цахилгаан үйлдвэрлэж байна.

BIPV MONGOLIA

НОГООН БАРИЛГА + ЭРЧИМ ХҮЧ:

BIPV технологийн дэлхийн чиг хандлага
Барилгын салбар нь дэлхийн хүлэмжийн хийн ялгарлын 37 хувийг дангаараа бүрдүүлдэг гэж IEA мэдээлсэн.

Хотжилт нэмэгдэж, эрчим хүчний хэрэглээ өсөхийн хэрээр барилга өөрөө эрчим хүчний хэрэглэгч биш, харин эрчим хүч үйлдвэрлэгч болох шаардлага улам тодорсон хэрэгцээнээс үүссэн инноваци юм.

Энэхүү эрэлт хэрэгцээний гол шийдэл нь BIPV технологи юм. Эрчим хүчээ өөрийгөө хангах барилга (Net-Zero Building) Европын холбоо 2030 оноос "Net-Zero" барилгыг стандарт болгохоор төлөвлөсөн бөгөөд Бельги, Нидерланд, Дани зэрэг улсууд BIPV фасадтай орон сууц, оффисын цогцолборыг үе шаттайгаар ашиглалтад оруулж эхэлсэн.

Жишээ:
Амстердамын The Edge оффис жилд өөрийн хэрэглээнээс илүү эрчим хүч үйлдвэрлэдэг.
Швейцарийн Solar Sihlcity төв фасадаараа жилд 330 МВт.ц эрчим хүч үйлдвэрлэж, 100% сэргээгдэх эх үүсвэрт шилжсэн.



Зах зээл:

Дэлхийн BIPV зах зээл 2024 онд ойролцоогоор US\$ 21.4 тэрбум байсан ба 2035 он гэхэд US\$ 204.6 тэрбум хүрэх төлөвтэй — жилд дунджаар ~22.8% CAGR. **Эх сурвалж:** (journalofenvironmentalnews.com)
BIPV модулиуд нь барилгын дээвэр, фасад, цонх зэрэг бүрээс нь уламжлалт материалуудыг орлож, барилга нь зөвхөн орон байшин биш, "цуцралт (skin) + эрчим хүчний үүсгүүр" болж хувирч байна.
(IEA-PVPS, Grand View Research)

Давуу талууд:

Эрчим хүчний хэрэглээг хангах, төвлөрсөн сүлжээнээс хамаарал багасгах (cervicornconsulting.com)
Барилгын материал, халаалт /цаг уурын зардал бууруулах (ijpeds.iaescore.com)
"Ногоон барилга", "Net-Zero Building" концепцтой нийцэх (MDPI)



Жишиг төсөл 2:

БНХАУ-ын Юнань мужийн Лижан хотод байдаг БЕТОН ЗУУРМАГИЙН ҮЙЛДВЭР 2021 онд ашиглалтанд орсон.
BIPV шилээр хийсэн фасадаараа өөрийн хэрэглээг хангаж илүү гарсан эрчим хүчээ улсад нийлүүлж агаарын бохирдолд хувь нэмрээ оруулсаар байна. Тус хот нь хавар мэт сэрүүн уур амьсгалтай тул дулаан үйлдвэрлэхэд эрчим хүчээ зарцуулдаг байна.

ХОТЫН ТӨВИЙН ДАХИН ТӨЛӨВЛӨЛТӨД BIPV ЦАХИЛГААН СТАНЦУУД ЗОНХИЛЖ БАЙНА

Дэлхийн томоохон хотуудын төвд шинэ цахилгаан станц барих боломж хязгаарлагдмал болсон тул "distributed generation" буюу барилга тус бүр эрчим хүч үйлдвэрлэх хэлбэр давамгайлж байна.

Тунгалаг BIPV (Solar Glass) тренд

Shanghai AI Tower – фасадаараа жилд 17% эрчим хүчээ өөрөө үйлдвэрлэдэг. SwissTech Convention Center – BIPV цонх ашиглан өдрийн гэрэл ба халалтыг 30% бууруулсан нь AC буюу хөргөлтийн зардлаа багасгаж чадсан. **Эх сурвалж:** (arXiv)

Яагаад улс орнууд VII үеийн сэргээгдэх эрчим хүчийг түлхүү нэвтрүүлж байна вэ?

Эрчим хүчний үнэ өссөн. 2022 оноос хойш Европын цахилгааны үнэ дунджаар 40–60% өссөн.
Уур амьсгалын нөлөөллийг бууруулах – Барилгын хэрэглээний CO₂ ялгарлыг бууруулах хэрэгцээнээс үүдэлтэй.
Хотын агаарын бохирдлыг бууруулах – хот дотор шууд цэвэр эрчим хүч үйлдвэрлэх нь нүүрсний хэрэглээг багасгаж иргэдийн эрүүл таатай орчинд амьдруулах бодлогод нийцэж байна.

Дүгнэлт: Монголд BIPV технологи нэвтэрч ногоон санхүүгийн бүтээгдэхүүн болсон байна. Дэлхийн улс орнууд барилгыг зөвхөн хэрэглэгч бус, эрчим хүч үйлдвэрлэгч ухаалаг систем болгон хөгжүүлж байна. Монгол Улсад BIPV технологийг нэвтрүүлснээр хотын төвлөрсөн дулаан, цахилгааны ачааллыг бууруулах, утаа, CO₂ ялгарлыг багасгах, "ногоон барилга" концепцийн хэрэгжилтийг дэмжих боломжтой.

Монголын барилгын салбарт тогтвортой хөгжлийн шинэ үеийг нээж байна. Энэ нь МУ-ын ногоон барилгын стандартыг ахиулж ногоон санхүүжилтийг татах гол аргачлалыг боловсруулаад байна.

Ногоон барилгын A+ зэрэглэл болох стандартуудыг (ISO 23237-2023, GB/T 37655-2019, DB51/T199-2022) Монгол улсад Монгол улсын засгийн газар, Эрчим хүчний яам, ХББОСЯ, Стандарт хэмжилзүйн газрын дэмжлэгтэйгээр нутагшуулж, Барилгын хөгжлийн төвтэй хамтарч BIPV инженер бэлтгэх сургалтуудыг инженерийн багц сургалтанд хамруулж зохион байгуулж байна. Сургалтын хуваарийг "Барилгын төсөвчдийн холбоо" гаргаж зохион байгуулж байна.

BIPV технологийн чухал үзүүлэлтүүд нь "Богино гүйдлийн хүчдэл нь 2.30 А болон Галын аюулгүй байдал А зэрэглэл"-тэй болсон нь сэргээгдэх эрчим хүчний хэрэглээнээс хэрэглэгч нарын хамгийн ихээр айдаг эрсдэлүүдийг цогцоор нь шийдсэн инноваци болж чаджээ.

Эх сурвалжууд

journalofenvironmentalnews.com — BIPV Market Report
IEA-PVPS — Coloured BIPV Report
Grand View Research — BIPV Market Analysis
cervicornconsulting.com — BIPV Overview
ijpeds.iaescore.com — Energy & Cost Study
MDPI — Net-Zero Buildings & BIPV
NYC.gov — Local Law 92 & 94, Solar & Green Roofs
arXiv.org — BIPV Global Urban Study
Brooklyn SolarWorks — NYC BIPV Insights



BIPV MONGOLIA

3

ВІРV ЖИШИГ ТӨСӨЛ 3:

Шанхайн цахилгаан эрчим хүчний төвийн барилга

Суурилуулсан хүчин чадал 171 кВт
Шанхай хотын Пудун Шинэ бүсэд байрладаг Энэхүү төсөл нь барилгад нэгдсэн фотоэлектрик (BIPV)-ийг барилгын фасадын системтэй хослуулсан хэрэглээ юм.

Жилийн цахилгаан үйлдвэрлэл нь 117,200 кВт.цаг хүрч болох бөгөөд энэ нь нүүрстөрөгчийн давхар ислийн ялгарлыг 116.85 тонноор бууруулж, жилдээ 46.88 тонн стандарт нүүрсийг хэмнэж, шар тоосны ялгарлыг 31.88 тонноор, хүхрийн давхар ислийн ялгарлыг 3.52 тонноор бууруулсантай тэнцүү гэж тооцдог.

Үүгээр CARBON MARKET дээр арилжаанд оролцох боломжтой. Учир нь удирдлагын систем үнэн бодит мониторинг системтэй. Гар удирдлагагүй тул гадны нөлөөлөл үгүй. Энэхүү барилга нь 2022 онд ашиглалтанд орсон.



ИЛҮҮ ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЛИЙГ:



7227 0002



bipvmn@outlook.com
info@bipv.mn



www.bipv.mn

4

ВІРV ЖИШИГ ТӨСӨЛ 4:

0 Карбон – Ногоон нисэх буудал

БНХАУ-ын Сямэнь-д Тайкоо Сяньань олон улсын нисэх онгоцны буудлын засвар үйлчилгээний төв нь LEED Platinum гэрчилгээ авсан бөгөөд Азидаа нисэх онгоцны засвар үйлчилгээний байгууламжийн төрөлдөө хамгийн өндөр түвшний гэрчилгээг авсан анхны нүүрстөрөгчгүй нисэх онгоцны буудал болжээ.

Одоогийн байдлаар Хятадын терминалын барилгуудын хамгийн том дээврийн фотоэлектрик систем болох Сямэнь Сяньань олон улсын нисэх онгоцны буудлын тээврийн төвийн BIPV шил нь албан ёсоор цахилгаан сүлжээнд холбогдож, 2106 ширхэг BIPV эрчим хүч үйлдвэрлэгч шил нь жилд 13 сая киловатт цаг цэвэр цахилгаан үйлдвэрлэж байна.


13 сая киловатт цаг гэдэг нь юу гэсэн үг вэ?

Жишээлбэл, хэрэв дундаж өрх жилд 4200 киловатт цаг цахилгаан ашигладаг гэж үзвэл жилд 3000 ийм хэрэглээтэй өрхийг эрчим хүчээр хангах боломжтой.

Энэхүү LEED ногоон нисэх онгоцны буудлыг бий болгохын тулд ногоон эрчим хүч буюу нүүрстөрөгч багатай хэрэглээнээс гадна дулаан алдагдалгүй байдал нь BIPV технологид байдаг тул давхар үзүүлэлт болжээ. Мөн нарны хэт ягаан туяанаас хамгаалдаг тул барилга доторх тавилга эд зүйлсийг элэгдэл хоргодолоос нь хамгаалдаг. Нэмээд хэрэглээний усны менежментийг хослуулсанаараа байгаль орчинд ээлтэй хэмнэлтийн системүүдийг цогцоор нь шийдсэн болно.

ZERO CARBON AIRPORT

Онгоц байрлах ангарын өрөөтэй. Дэлхийд томдоо орох онгоцны засварын төв энд байдаг бөгөөд жилд зөвхөн онгоцны засвар үйлчилгээнд орохоор зорьж ирсэн олон улсын үйлчлүүлэгч нараас өндөр үр ашиг олж амжилттай ажилласаар байна.



TERELJ MOUNTAIN LODGE



HOTEL

The Terelj Mountain Lodge has the capacity of 125 people. We offer Deluxe, Standard, Double and Familyrooms with choices of 1-4 beds. There are also 20 Hunnu gers that present the amazing combination of modern and traditional Mongolian architecture. Each room in the resort complex is unique and has different features decorated with natural wood and stones to provide guests with comfort.

DINING

With the most advanced new technology incorporated in our kitchen our restaurant has the capacity to serve 128 people. We offer the opportunity to taste our chef's delicious meals, drink world's best wines and freshly brewed coffee, while enjoying the view of beautiful nature. For business or private meetings please reserve our comfortable VIP lounge with a fire place



Add: Nalaikh district, 6th khoroo, Gorkhi-Terelj National Park, Zalaat am
Web: www.tereljmountainlodge.mn
E-mail: tereljmountainlodge@gmail.com
Tel: 7023 9999, 8090 5588, 80808300
Facebook: [tereljmountainlodge](https://www.facebook.com/tereljmountainlodge)

Share your holidays best moments like a local with TourSIM!

With our TourSIM prepaid plans, you can enjoy the following benefits:

- ✓ High-speed 4G data on Unitel's nationwide network
- ✓ Unlimited calling and texting to all networks in Mongolia
- ✓ Prepaid plan choices tailored to fit your needs
- ✓ Convenient Pick-Up and Top-Up options
- ✓ No contracts required

10 Days Plan

Data
15GB DATA

Validity
10 days

25'000₮

20 Days Plan

Data
25GB DATA

Validity
20 days

40'000₮

30 Days Plan

Data
50GB DATA

Validity
30 days

70'000₮

*Please note that with this Tour SIM, calling and messaging are not available-this SIM is designed only for fast, uninterrupted data!
*If you wish to avail of a TourSIM plan that includes unlimited calling and texting capabilities, you can add the Voice & SMS service to your data plan at our branches located near your destination upon your arrival in Mongolia, at no extra cost



MONGOLIA'S
WIDEST NETWORK
Experience an amazing journey



You can find TourSIM cards at

Chinggis Khaan International Airport
F1 in the public area

All Unitel branches

Tour operators

MONGOLIA'S WIDEST NETWORK

 Experience an amazing journey

